

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭД 2025 ОНЫ 03 САРЫН 07-НЫ ӨДРИЙН ССАЖЗЯ/25/22 ТООТ ГЭРЭЭНИЙ ДАГУУ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2026 оны 02 дүгээр сарын 05-ны өдөр

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэл байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая.төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
	1	2	3	4	5	6	7
<b>Стратеги төлөвлөгөөний зорилго 1</b>							
<b>Монгол Улсын гадаад сурталчилгааг өргөжүүлэн, жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх</b>							
Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн үндэслэл:							
<p>"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.44-д "Аялал жуулчлалын гадаад сурталчилгаа, маркетингийн үйл ажиллагааг эрчимжүүлж, олон улсын аялал жуулчлалын сүлжээнд нэгдэнэ.", 2023-2025 оныг "Монголд зочлох жил" болгон зарлах тухай Монгол Улсын Засгийн газрын 264 дүгээр тогтоол; Түлхүүр үг батлах тухай Монгол Улсын Засгийн газрын 433 дугаар тогтоолын 1-д "Монгол Улсын гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах үйл ажиллагаанд "Go Mongolia" түлхүүр үгийг, түүнийг дагалдах "Always. Moving" үгийг хэрэглэхээр тогтсугай.", 3-д "Түлхүүр үгийг Монгол Улсын гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах үйл ажиллагаанд хэрэглэж, олон улсад таниулах ажлыг зохион байгуулах", 5-д "Түлхүүр үгийг Монгол Улсын гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах үйл ажиллагаанд хэрэглэж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн холбогдох байгууллагад үүрэг болгосугай.", Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 4.5.2-д "Монгол Улсыг гадаад орнуудад сурталчлах ажлыг нэгдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулах"; Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогын 4.3.2-д "зорилтот зах зээлийн орнуудын онцлогт тохирсон маркетингийн үйл ажиллагааг эрчимжүүлж, цар хүрээг нэмэгдүүлэх", 4.3.6-д "олон улсын үзэсгэлэнд Монгол Улсыг сурталчлахад төр, хувийн хэвшлийн түншлэл, салбар дундын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх"; ССАЖЗЯ, АЖМХ-ны "Төрийн зарим чиг үүргийг засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай гэрээ"-ний 2.1.1-д "Монгол Улсын байгаль, түүх, соёлын онцлогийг гадаадад сурталчлах" гэж заасныг тус тус үндэслэн</p>							
1.1.	Зорилт 1. Зорилтот орнуудад "Go Mongolia" рөүдшоу зохион байгуулж, Монгол Улсыг сурталчлах						
1.1.1.						I улиралд Монгол Улсыг сурталчилсан рөүд шоуг гадаад улсад зохион байгуулаагүй.	
1.2.	Зорилт 2. Олон улсын үзэсгэлэнд оролцож, Монгол Улсыг сурталчлах						

2024 онд Монгол улсад 808,218 жуулчид ирсний 32.6%-ийг буюу 263,479 нь Европын жуулчид байгаа тул энэхүү өсөлтийг дэмжих шаардлагатай тул ХБНГУ-ын Берлин хотын Messe Berlin олон улсын үзэсгэлэнгийн танхимд "ITB Berlin 2025" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд ССАЖЗЯ-ны чиг үүргийн хүрээнд АЖМХ-ны ажлын алба болон Европ зах зээлийн салбар холбооны зохион байгуулалт дор Монгол Улсын 13 байгууллага оролцож Монгол Улсаа сурталчлах, өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг танилцуулах, B2B уулзалт хийх үйл ажиллагааг явуулав. Түүнчлэн НАЖГ 40 сая төгрөгөөр дэмжлэг үзүүлэв. Оролцогч аж ахуйн нэгж, байгууллагуудыг дурдвал,

1. "Эй стар Монголиа" ХХК
2. "Эксплор Монголиа" ХХК
3. "Голден гоби" ХХК
4. "Идэр экспедишн" ХХК
5. "Амикус" ХХК
6. "Жуулчин" ХХК
7. "Цолмон трэйвел" ХХК
8. "Дөрөө трэйвел" ХХК
9. "Нью жуулчин турс" ХХК
10. "Грейт Чингис турс & экспедишнс" ХХК
11. "Но на трэйвел" ХХК
12. "Рара авис" ХХК
13. "Анлок стэппе Монголиа" ХХК

НАЖГ-ын гадаад харилцааны мэргэжилтэн, АЖМХ-ны ажилтнууд томиллоотоор явсан. Дэмжигч болон хамтран ажиллагчаар Нийслэлийн аялал жуулчлалын газар, Говь ХК, Чингис хаан Үндэсний музейн "Хаан найрал чуулга" ажилласан. Тус үзэсгэлэнд Монголын улс 14 дэх жилдээ нэгдсэн зохион байгуулалттайгаар оролцсон байна. Үзэсгэлэнгийн үеэр Монгол улсыг сурталчлах "Go Mongolia" арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан хүлээн авалт, урлагийн тоглолтууд нь Монголын соёлын өвийг дэлхий дахинд сурталчлах чухал үйл явдал болсон. ITB Berlin 2025 олон улсын үзэсгэлэнд 170 улсын 5,800 төр, хувийн хэвшлийн байгууллагууд оролцсон бөгөөд 3 өдрийн хугацаанд ойролцоогоор 100,000 орчим бүртгэлтэй оролцогчид арга хэмжээний танхимд нэвтэрсэн. АЖМХ нь аялал жуулчлалын салбарын төрийн болон хувийн хэвшлийн 60 орчим байгууллагуудтай хамтын ажиллагааны уулзалтуудыг зохион байгуулснаас жишээ болгон дурдвал,

АТТА – 2025 оны намар хамтран хэрэгжүүлэх адал явдалт аялал жуулчлалын мэргэшсэн хөтөч тайлбарлагчийг бэлдэх сургалтыг Монгол Улсад зохион байгуулах;

ITB China – Монголын зах зээлийг сонирхож буй Хятадын аялал жуулчлалын компаниудад Монголыг таниулах, хамтын ажиллагааг эхлүүлэх уулзалт, хүлээн авалтыг зохион байгуулсан;

Дэлхийн алдарт CNBC телевизэд Монголын аялал жуулчлалын өнөөгийн байдал, чиг хандлагын талаар ярилцлага өгсөн гэх мэт.

2025.03.04 (Өдөр I)

Үзэсгэлэнгийн эхний өдөр – ITB Berlin 2025-д Монгол Улсын павильон Messe Berlin, Hall-26C, Stand No. 301 байршилд байрлаж, үндэсний өв соёл, байгаль, аялал жуулчлалын олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг танилцуулсан нь олон улсын зочдын анхаарлыг татсан. Энэ өдөр гадаадын 20 гаруй байгууллагатай албан уулзалтуудыг хийснээс дурдвал, National Geographic, NBC Universal зэрэг дэлхийн хэмжээний байгууллагуудтай гадаад сурталчилгааны боломжуудын талаар;

ITB China, ITB Asia, United Airlines, Хайнанийн Аялал Жуулчлалын Товчоо, Польшийн Аялал Жуулчлалын Байгууллага зэрэг олон улсын түншүүдтэй хамтын ажиллагааны талаар;

National Geographic сэтгүүлийн редакцтай Монгол Улсыг европын зах зээлд хэрхэн сурталчлахад National Geographic хэрхэн оролцох талаар;

ITB China үзэсгэлэнгийн захиргаатай Монголын зах зээлийг сонирхож буй Хятадын томоохон 8 компанийн төлөөллийг өөрсдийн павильон дээрээ урин Монголын аялал жуулчлалын топ чиглэл, бүтээгдэхүүнийг танилцуулж, ирээдүйн хамтын ажиллагааны эхлэлийг тавьсан. Тус уулзалтад Монголын 10 тур операторын төлөөлөл оролцож бизнес уулзалтуудыг хийсэн зэрэг ажлууд орно.

2025.03.05 (Өдөр II)

Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх санаачилгын хүрээнд Германы өвлийн аялал өндөр хөгжсөн бүс нутгуудад туршлага судлах аялал зохион байгуулах.

Бидний уулзалтаар хоёр улсын аялал жуулчлалын хамтын ажиллагаа, Германы зах зээлд Монгол Улсын аялал жуулчлалыг танигдуулах стратеги, мөн дараагийн ажлуудын талаар тохиролцлоо. Элчин сайд Монгол Улсын аялал жуулчлалын салбарт олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх болно гэж үзэж байна.

Бусад өдрүүдэд

Германы олон нийтийн томоохон арга хэмжээнүүдийн нэг болох "Турн Фест 2025" дээр Монгол Улсыг сурталчилсан павильон ажиллуулах талаар Германы Гимнастикийн Холбооны Нийтийн Гимнастикийн Техникийн Хорооны ерөнхийлөгч Детлеф Маннтай санал солилцов.

ITB BERLIN 2025 үзэсгэлэнгийн санал, зөвлөмж

Үзэсгэлэнд оролцсон байдал: ITB Berlin 2025 үзэсгэлэнд Монгол Улс амжилттай оролцож, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өөрийн орны онцлог бүтээгдэхүүн, аяллын боломжуудыг сурталчилж чадсан. Оролцогчид болон хамтран ажиллагч байгууллагуудын зүгээс Монголын павильоны зохион байгуулалт, үзүүлбэр, уулзалтын чанарыг өндөр үнэлсэн.

Давуу талууд: Монголын аялал жуулчлалын салбарын төлөөллүүд олон улсын зах зээлд идэвхтэй танигдаж, гадаад хамтын ажиллагааны хүрээгээ өргөжүүлсэн. Олон улсын томоохон компани, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай үр дүнтэй уулзалт хийж, цаашдын хамтын ажиллагааны боломжуудыг хэлэлцсэн. "Go Mongolia" хүлээн авалт, соёлын арга хэмжээ амжилттай зохион байгуулагдаж, зочдын сонирхлыг татсан.

Санхүүжилтийн асуудал: Оролцогч тур операторууд компаниуд өөрсдийн зүгээс талбайн түрээс болон тохижилтын төлбөрийг урьдчилан хийсэн бөгөөд тэдгээр байгууллагуудад төлбөрийг нөхөн олгосон. Сүүлийн оролцсон бүх үзэсгэлэнгүүдэд үргэлж нөхөж гэрээ байгуулдаг, нөхөж төлбөр төлдөг нь манай байгууллагын ирээдүйн хамтын ажиллагаанд муу нэр үлдээх эрсдэлтэй.

Урьдчилсан төлөвлөлт: Үзэсгэлэнд оролцох бэлтгэл ажлыг илүү эртнээс нарийвчлан төлөвлөж, ССАЖЗЯ-аас талбайн түрээс, тохижилтын төлбөрийг жил бүрийн 1-р сарын эхний 7 хоногт шийдвэрлэж байх шаардлагатай байна.

Маркетинг, сурталчилгаа: ITB Berlin 2025-ийн хүрээнд хийгдсэн уулзалтууд, хамтын ажиллагааны боломжуудыг илүү үр дүнтэй ашиглах, үргэлжлүүлэх шаардлагатай.

1.2.2.	"SITF 2025" БНСУ-ын Сөүл хотод зохион байгуулагдсан Сөүлийн олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн	100 (30) Үзэсгэлэнгийн нийт төлбөр 157,6 болов	Оролцсон олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, арга хэмжээний тоо	Монголд зочлох жилийн хүрээнд олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд тогтмол оролцсон.	Монгол Улсыг гадаадад сурталчлах 6-7 олон улсын үзэсгэлэн, яармаг, 1-3 арга хэмжээнд оролцсон байна.	<p>2025 оны 06 дугаар сарын 05-наас 08-ны өдрүүдэд Сөүл хотын үзэсгэлэнгийн төв (COEX Exhibition Centre)-д зохион байгуулагдав. АЖМХ болон Монголын Солонгос зах зээлийн аялал жуулчлалын салбар холбоо нь үзэсгэлэнд оролцох ажлын зохион байгуулалтыг хариуцаж ажилласан. Тус үзэсгэлэнд оролцохыг сонирхсон аялал жуулчлалын байгууллагуудын бүртгэлийг 2025 оны 02 сарын 24-ны өдөр АЖМХ-ны фэйсбүүк хуудас дээр эхлүүлсэн бөгөөд нийт 11 аж ахуйн нэгж, байгууллага бүртгүүлсэн. 2024 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр бүртгүүлсэн компаниудын төлөөллүүдийг урьж, тус үзэсгэлэнгийн тухай болон Монгол Улс оролцохын ач холбогдлын талаарх мэдээллүүдийг хүргэсэн.</p> <p>Монгол Улсын хувьд өнгөрсөн онд ирсэн нийт жуулчдын 24 хувийг БНСУ-ын жуулчид эзэлж буй нь хоёр улсын аялал жуулчлалын харилцаа эрчимтэй хөгжиж байгааг харуулж байна. Иймд уг өсөлтийг хадгалах, цаашид улам нэмэгдүүлэх зорилгоор Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам (ССАЖЗЯ), Нийслэлийн аялал жуулчлалын газар (НАЖГ), Улаанбаатар Театр, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо - НЭЗХЭ болон МОКТА салбар холбооны 9 тур оператор компанийн 28 төлөөлөл хамтран оролцсон бөгөөд ССАЖЗЯ-ыг төлөөлөн Гадаад харилцааны дарга Б.Цэнгүүн, АЖБЗГ-ын мэргэжилтэн А.Заяа нар оролцов. НАЖГ Улаанбаатар чуулгын уран бүтээлчдийг оролцуулж дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Оролцогч байгууллагууд:  1. EXPAT MONGOLIA  2. NOMEKO TOUR  3. ETU TRAVEL  4. GC TOUR  5. LET'S TRAVEL  6. JOY MONGOLIA TRAVEL  7. IDC TOUR  8. EXPLORE MONGOLIA  9. MONGOLIA VISION TOURS</p> <p>Түүнчлэн Монгол улс SITF-2025 Сөүлийн олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд амжилттай оролцож BEST BOOTH DESIGN буюу Шилдэг загвар дизайн хийсэн улсаар шалгарлаа. Энэ удаагийн талбайн тохижилтын концепт дизайн нь 13-р зууны эртний хаадын цомцог гэрийг модоор урлаж Монгол бичигтэй хослуулан өв соёл үндэсний онцлогоо харуулахаар зорьсон юм. Мөн оролцогч байгууллагууд:  1. Монгол гэр  2. Монгол боодог  3. Монгол дээл  4. Монгол говийн аялал  5. Монголын аяллын танилцуулга  6. Монгол морь  7. Монголын говь, Мазаалай</p> <p>гэсэн сэдвүүдээр үндсэн тайзнаа илтгэл тавилаа. 4 өдрийн турш B2B уулзалтыг амжилттай хийж дунджаар 1 байгууллага 10-аад компанитай B2B уулзалт хийлээ. Стэнд болон тохижилтын төлбөр 2025.06.02-ны өдөр 70 хувь буюу 70 сая төгрөг орж ирсэн. Үлдэгдэл 30 сая төгрөг одоог хүртэл буюу 2026.02.05 хүртэл ороогүй болно.</p> <p>Жич: ССАЖЗЯ болон НАЖГ-аас гаргаж буй санхүүжилт нь тухайн үзэсгэлэнгийн талбайн түрээс, үзэсгэлэнгийн тохижилт, АЖМХ болон яамны төлөөллийн томилолтын зардал, урлаг соёлын ажилтнуудын томилолт болон эдгээр ажилтнуудын нислэгийн төлбөр зэрэгт зарцуулагддаг ба оролцож буй байгууллагууд нислэгийн төлбөр, хэвлэмэл брошурын зардал, байр, хоол, унааны төлбөр зэргээс гадна тохижилт, талбайн түрээсийн дутуу зардал зэргийг хариуцдаг.</p>	100%
--------	--	---	--	--	--	--	------

	<p>China Outbound Travel &amp; Tourism Market (COTTM) БНХАУ-ын Бээжин хотод зохион байгуулагдсан олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн</p>	<p>170 (ССАЖЗЯ) 30 (НАЖГ) Үзэсгэлэнгийн нийт зардал 200 сая болов.</p>	<p>Оролцсон олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, арга хэмжээний тоо</p>	<p>Монголд зочлох жилийн хүрээнд олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд тогтмол оролцсон.</p>	<p>Монгол Улсыг гадаадад сурталчлах 6-7 олон улсын үзэсгэлэн, яармаг, 1-3 арга хэмжээнд оролцсон байна.</p>	<p>2024 онд Монгол Улсад 808,956 жуулчин ирсний 28% буюу 221,225 нь Хятад жуулчид байгаа тул энэ өсөлтийг тогтвортой нэмэгдүүлэх бодлого баримтлах шаардлагатай тул БНХАУ-ын "China Outbound Travel &amp; Tourism Market – 2025 (COTTM)" 17 дахь удаагийн олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн 2025 оны 04 дүгээр сарын 24-нөөс 26-ны өдрүүдэд Бээжин хотын Хятадын Үндэсний Хөдөө Аж Ахуйн Үзэсгэлэнгийн төвд зохион байгуулагдсан үзэсгэлэнд оролцсон. Тус үзэсгэлэнд оролцохыг сонирхсон аялал жуулчлалын байгууллагуудын бүртгэлийг 2025 оны 03 сарын 07-ны өдөр АЖМХ-ны фэйсбүүк хуудас дээр эхлүүлсэн бөгөөд нийт 11 аж ахуйн нэгж, байгууллага бүртгүүлсэн. Эдгээр компаниудын төлөөллүүдийг Хятад Зах Зээлийн Салбар Холбоо урьж, 2025 оны 3 дугаар сарын 19, 4 дүгээр сарын 1 болон 3-ны өдрүүдэд тус тус хуралдаж үзэсгэлэнд хэрхэн оролцох талаар ярилцав. АЖМХ-ны Хятад Зах Зээлийн Салбар Холбоо нь үзэсгэлэнгийн зохион байгуулалтыг хариуцах бөгөөд нийт 60м2 талбай түрээслэн авч, Go Mongolia брэндийн доор тохижилт хийж оролцохоор шийдвэрлэсэн. Тус үзэсгэлэнг ССАЖЗЯ, АЖМХ-НЭЗХЭ, ХЗЗСХ хамтран зохион байгуулж НАЖГ 30 сая төгрөг болон Улаанбаатар чуулгын хамт олны урлагийн тоглолтоор дэмжиж оролцов. Үзэсгэлэнд оролцохоор бүртгүүлсэн компаниудыг дурдвал,  1. Хорсбаэк адвенчер Монголиа ХХК  2. Актив адвенчер турс Монголиа ХХК  3. Отгоодор ХХК  4. И Ти Ю трэйвел ХХК  5. Айланд трэйвел ХХК  6. Жи Си тур ХХК  7. Эй Би трэйвел  8. Хөвсгөл трэйвел ХХК  9. Шинэ зууч трэйвел ХХК  10. Нью жуулчин турс ХХК  COTTM 2025 олон улсын үзэсгэлэнд Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо 2 дахь жилдээ дараалан оролцлоо.  Үзэсгэлэнгийн үеэр Монгол улсыг сурталчлах "Go Mongolia" арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан Улаанбаатар театрын урлагийн тоглолтууд нь Монголын соёлын өвийг дэлхий дахинд сурталчлах чухал үйл явдал болсон. Мөн АЖМХ-НЭЗХЭ-ийн Дэд ерөнхийлөгч В. Батзориг үзэсгэлэнгийн хүрээнд зохион байгуулагдсан олон улсын хэлэлцүүлгийн үеэр "Монголын аялал жуулчлалын салбар дахь хөрөнгө оруулалтын боломж" сэдвээр танилцуулга хийсэн.  Хятад зах зээлийн Салбар холбооны гишүүн Н.Сарангэрэл "Монгол орны байгаль аялал жуулчлалын онцлог" сэдвээр тусгай танилцуулга хийж, Монголын ховор онгон байгаль, улирлын онцлогт тохирсон аяллын багцууд, эко жуулчлалын хөгжлийн чиг хандлага, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын сайн жишээ зэргийг үзэсгэлэнгийн үеэр олон нийтэд хүргэсэн.  18 дахь удаагийн Хятадын гадаад аялал жуулчлалын зах зээл (COTTM-2025) албан ёсоор нээлтээ хийж, COTTM-2025 үзэсгэлэнд 45 орны 150 гаруй олон улсын аялал жуулчлалын ханган нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч оролцож, Хятадын 3000 гаруй аялал жуулчлалын мэргэжилтнүүд үзэсгэлэнг үзэж сонирхов.  COTTM-д Орос, Египет, Тунис, Балба, Монгол, Перу, Оман, Грекийн Ионы арлууд зэрэг гадаадын болон бүс нутгийн аялал жуулчлалын зөвлөлүүд оролцов. Үүний зэрэгцээ "COTTM бага хурал"-д Хятадын гадаадад аялах салбарын 30 гаруй гол тоглогч үг хэлж, Хятадын ирээдүйн аялал жуулчлалыг хөгжүүлэх шинэ чиг хандлага, боломжуудыг судлав.  Хятад болон Европын зах зээлд ажилладаг 10 хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд бизнес уулзалт хийх, Монгол улсыг сурталчлах, жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх чиглэлээр ажилласан.  • COTTM нь дэлхийн аялал жуулчлалын чиглэлүүдийг нэг дор цуглуулж, ялангуяа "шинэлэг, онцгой, захиалгат" аялал жуулчлалын бүтээгдэхүүн нийлүүлэгчдийг, түүнчлэн "Нэг бүс, Нэг зам" санаачилгын орнуудын төлөөлөгчдийг нэгтгэдэг онцлогтой үзэсгэлэн юм.  • COTTM үзэсгэлэнд 5,000 гаруй Хятадын аялал жуулчлалын тур оператор компани оролцсон байна.  • COTTM нь Хятадын тэргүүлэх гадагшаа аялал жуулчлалын тур операторуудын хүчтэй дэмжлэгийг хүлээсэн арга хэмжээ юм.  • COTTM нь "Нэг бүс, Нэг зам" санаачилгын үндэсний стратегийг хэрэгжүүлж, 2025 оны "COTTM Conference" арга хэмжээний хүрээнд "Гадагшаа Аялал Жуулчлалын Хөрөнгө Оруулалтын Форум"-ыг зохион байгуулсан. Энэ форум нь хэд хэдэн улсын элчин сайдын яамд, аялал жуулчлалын байгууллагуудыг нэгтгэдэг ба эдгээр байгууллагуудын аялал жуулчлалын хөрөнгө оруулалтын бодлого, чанартай төсөл, хөгжлийн боломжуудыг танилцуулах арга хэмжээ болж өнгөрөв.</p>	<p>100%</p>
	<p>Үзэсгэлэнд оролцсон байдал  COTTM 2025 үзэсгэлэнд Монгол Улс амжилттай оролцож, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өөрийн орны онцлог бүтээгдэхүүн, аяллын боломжуудыг сурталчиллав. Оролцогчид</p>						



Бодит үр дүнтэй алхам болсон гэж үзэж байна.

1.2.4	Будапешт Рөүд шоу - Нийслэлийн соёлын өдрүүд		олон улсад зохион байгуулсан аялал жуулчлалын рөүд шоуны тоо	Монголд зочлох жилийн хүрээнд олон улсад аялал жуулчлалын рөүд шоу зохион байгуулсан.	Монгол Улсыг гадаадад сурталчлах 6-7 олон улсын үзэсгэлэн, ярмаг, 1-3 арга хэмжээнд оролцсон байна.	<p>2023-2025 оныг "Монголд зочлох жил" болгон зарлах тухай Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 07 сарын 05-ны өдрийн 264 дүгээр тогтоол батлагдсан. "Монголд зочлох жил"-ийг 2028 он хүртэл үргэлжлүүлэх шийдвэр гарсан. Үүний зэрэгцээ, "Go Mongolia" брэндийг хувийн хэвшлийн байгууллагууд дотоод, гадаадын бүхий л үйл ажиллагаандаа ашиглаж, улс орноо олон улсад нэг брэндийн дор сурталчлахыг МУ-ын Засгийн Газраас уриалсан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд 2030 он гэхэд 2 сая жуулчин хүлээн авах зорилт дэвшүүлсэн зэрэг Засгийн газрын бодлого, төлөвлөгөөт ажлын хүрээнд Унгар Рөүд Шоу – Улаанбаатарын Соёлын Өдрүүд 2025 арга хэмжээнд оролцож улс орноо сурталчлах, Европын зах зээлээс ирэх жуулчдын урсгалыг нэмэгдүүлэхэд энэхүү ажлын гол зорилго оршино.</p> <p>Монгол Улс болон Унгар Улс хооронд дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ойн хүрээнд "Улаанбаатарын Соёлын Өдрүүд" арга хэмжээ 2025 оны 5 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд Унгар улсын нийслэл Будапешт хотын Маргарет арал дээр боллоо. Тус арга хэмжээнд Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо – Нийтийн Эрх Зүйн Хуулийн Этгээдийн Европ Зах Зээлийн Салбар Холбооны 8 гишүүн тур оператор компани оролцсон.</p> <p>Оролцогч компаниуд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Цолмон ТрэивэлИдэр экспедишн</li> <li>2. Миллениум Турс</li> <li>3. Трэивел Он</li> <li>4. Блю Тур</li> <li>5. НоНа Фэмили</li> <li>6. Грэйт Чингис Экспедишн</li> <li>7. Ембүү Капитал</li> </ol> <p>Арга хэмжээний хүрээнд Монгол Улсаас Нийслэлийн Аялал Жуулчлалын Газар, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо- НЭЗХЭ-ийн төлөөллүүд Будапешт хотын Соёл, Спорт, Аялал Жуулчлал, Залуучуудын газар болон дипломат харилцаа хариуцсан албаны төлөөллүүдтэй албан ёсны уулзалт хийв.</p> <p>Уулзалтад Монголын талаас Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга Д.Батсүх, бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга С.Туул, АЖМХ-НЭЗХЭ-ийн гүйцэтгэх захирал М. Нарангэрэл, гадаад харилцааны менежер Ш.Анхбаяр, мөн Унгар Улсад суугаа Монгол Улсын Элчин сайдын яамны соёлын атташе Т.Бүрэнжаргал, хэлмэрч Ч.Энхбат нар оролцсон байна.</p> <p>Унгарын талаас Будапешт хотын Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга Коталин Датнер, Гадаад харилцааны газрын дарга Орсоля Хладони нар оролцож, хоёр улсын аялал жуулчлал, соёлын салбар дахь хамтын ажиллагааны боломжуудын талаар харилцан санал солилцов.</p> <p>Уулзалтын үеэр Коталин Датнер нь Будапешт хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ, хотын бодлогын чиг хандлагын талаар товч танилцуулга хийсэн бол Монголын талаас Д.Батсүх, М.Нарангэрэл нар Монгол Улсын аялал жуулчлалын хөгжил, жуулчин хүлээн авах бэлэн байдал, боломжуудын талаар мэдээлэл өгч, хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлэх сонирхлоо илэрхийллээ. Энэхүү уулзалт нь хоёр орны аялал жуулчлалын салбар дахь харилцаа, хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах эхлэл болж байна.</p> <p>Арга хэмжээний онцлох үйл явдлуудын нэг нь Унгар улсын иргэдэд зориулсан Монголын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний танилцуулга, сурталчилгааны өдөрлөг байв. Энэхүү өдөрлөгийг Монголын талаас оролцож буй 8 тур оператор компани хамтран зохион байгуулж, байгаль, соёл, нүүдлийн ахуй, адал явдалт аялал зэрэг Монгол Улсын голлох аялал жуулчлалын бүтээгдэхүүнүүдийг Унгарын үзэгчдэд танилцуулсан. Мөн олон нийтийн сонирхлыг татсан "Монголын талаар хэн сайн мэдэх вэ?" сэдэвт асуулт-хариултын тэмцээн амжилттай зохион байгуулагдаж, идэвхтэй оролцсон иргэд дундаас шалгарсан нэг атан Монгол Улсад аялах эрхийн бичгээр шагнуулсан байна. Уг шагналыг АЖМХ-НЭЗХЭ-ийн Европ зах зээлийн салбар холбооны гишүүн 8 байгууллага хамтран ивээн тэтгэв. Энэхүү арга хэмжээ нь Монгол орныг Унгарын жуулчдад илүү ойртуулж, аялал жуулчлалын салбар дахь бодит үр дүнтэй харилцааг өргөжүүлэх чухал алхам боллоо.</p>	100%
-------	--	--	--	---	---	---	------

1.2.5	"IFTM Top Resa (International & French Travel Market) 2025" олон улсын мэргэжлийн аялал жуулчлалын үзэсгэлэн	70 (ССАЖЗЯ) 42.5 (оролцогчид) Үзэсгэлэнгийн нийт зардал 84 сая	Оролцсон олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, арга хэмжээний тоо	Монголд зочлох жилийн хүрээнд олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд тогтмол оролцсон.	Монгол Улсыг гадаадад сурталчлах олон улсын 9 үзэсгэлэн, яармаг, 1-3 арга хэмжээнд оролцсон байна.	<p>"IFTM Top Resa 2025" 47 дахь удаагийн олон улсын мэргэжлийн аялал жуулчлалын үзэсгэлэн 2025 оны 09 дүгээр сарын 23, 24, 25-ны өдрүүдэд БНФУ-ын Парис хотод амжилттай болж өндөрлөлөө. Үзэсгэлэнд 177 зорин очих газрын 1650 брэнд, 16725 бизнес уулзалт, 32022 салбарын мэргэжилтнүүд оролцдог. Оролцогч байгууллагууд "GoMongolia" сурталчилгаа дор В033 тоот 16м2 талбайд амжилттай оролцов.</p> <p>Монгол улсыг төлөөлөн:</p> <ul style="list-style-type: none"> <li>· Соёл, спорт, аялал жуулчлалын яам</li> <li>· Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо -НЭЗХЭ</li> <li>· Европ зах зээлийн салбар холбоо болон хувийн хэвшлийн 5 компани Монгол улсаа сурталчлах, жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор 3 хоногийн турш ажилласан. Үүнд:       <ol style="list-style-type: none"> <li>1. ДМД Монгол ХХК</li> <li>2. Степиндимсе ХХК</li> <li>3. Анлок Стэл Монголиа ХХК</li> <li>4. Монгол Талын Мэлмий ХХК</li> <li>5. Номад Планет ХХК" гэсэн 5 тур оператор болно.</li> </ol> </li> </ul> <p>Нэг байгууллагаас 8,5 сая төгрөгний урьдчилгаа авч тохижилт болон бусад зүйлд зарцуулсан. Үзэсгэлэнгийн төлбөрийн 70 хувь болох 49 сая төгрөг 2025 оны 7 сарын 29-ний өдөр орж ирсэн. 2025 оны 12 сарын 26-нд үлдэгдэл 30 хувь орж ирсэн. Дараагийн IFTM Top Resa 2026 үзэсгэлэн нь 2026 оны 9 сарын 15-17-ны хооронд зохион байгуулагдана. Франц улсаас 2025 онд 8370 жуулчин ирсэн ба энэ нь өмнөх жилийнхээс 0.9 хувийн өсөлттэй байна.</p>	
	TEJ (Tourism Expo Japan) 2025" олон Улсын аялал жуулчлалын үзэсгэлэн	180 (ССАЖЗЯ) Үзэсгэлэнгийн нийт зардал 201,27	Оролцсон олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, арга хэмжээний тоо	Монголд зочлох жилийн хүрээнд олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд тогтмол оролцсон.	Монгол Улсыг гадаадад сурталчлах олон улсын 9 үзэсгэлэн, яармаг, 1-3 арга хэмжээнд оролцсон байна.	<p>"Tourism Expo Japan-2025" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн 2025 оны 09 дүгээр сарын 25, 26, 27,28-ний өдрүүдэд Япон Улсын Нагоя хотод амжилттай болж өндөрлөлөө. JAPAN EXPO TOURISM-2025" олон улсын үзэсгэлэнгийн нээлтийн арга хэмжээний үеэр зохион байгуулагчдын зүгээс уг үзэсгэлэн дэлхийн хэмжээнд хамгийн том үзэсгэлэн болж буйг олон нийтэд зарласан ба үзэсгэлэнд 82 улс, Японы 45 муж оролцож, нийт 1,474 бүүтэнд 1,350 компани, байгууллага оролцож байна. Оролцогч байгууллагууд "GoMongolia" сурталчилгаа дор F-049 тоот 54м2 талбайд 14 аж ахуйн нэгж амжилттай оролцов.</p> <p>Монгол улсыг төлөөлөн</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Соёл, спорт, аялал жуулчлалын яам</li> <li>2. Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо - НЭЗХЭ</li> <li>3. Aero Mongolia</li> <li>4. IRIS TOURS CO.,LTD アイリスツアーズ旅行会社</li> <li>5. JIGUUR</li> <li>6. ETU Travel Mongolia</li> <li>7. Amicus Travel Mongolia</li> <li>8. New Juulchin Tours</li> <li>9. Shine Zuuch Travel モンゴル旅行</li> <li>10. Алтантур - Altantour</li> <li>11. Jamo Grand</li> <li>12. Monster Travel - Travely</li> <li>13. H&amp;A Travel</li> <li>14. Ikh Khorum Hotel</li> </ol> <p>2025 оны 8 сарын 12-ны өдөр 126 сая төгрөг буюу 70 хувь нь орсон ба үлдэгдэл 30 хувь нь 2025 оны 12 сарын 26-ны өдөр орсон байна. Дараагийн Жапан expo Tourism-2026 үзэсгэлэн нь 2026 оны 9 дүгээр сард Япон Улсын Токио хотод болно.</p>	

1.2.6	WTM (World Travel Market) 2025" Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн	190 (ССАЖЗЯ) 231,5 (оролцогч байгууллагууд) Үзэсгэлэнгийн нийт зардал 381,590 орчим сая төгрөг болсон.	Оролцсон олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, арга хэмжээний тоо	Монголд зочлох жилийн хүрээнд олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд тогтмол оролцсон.	Монгол Улсыг гадаадад сурталчлах олон улсын 9 үзэсгэлэн, яармаг, 1-3 арга хэмжээнд оролцсон байна.	<p>"WORLD TRAVEL MARKET"-2025 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн 2025 оны 11 дүгээр сарын 4, 5, 6-ны өдрүүдэд Их Британий нийслэл Лондон хотноо амжилттай болж өндөрлөлөө. WORLD TRAVEL MARKET буюу WTM-2025" олон улсын үзэсгэлэнгийн нээлтийн арга хэмжээнд энэ 9 сард шинээр томилогдсон Спорт, Аялал жуулчлал, Иргэний нийгэм болон Залуучуудын яамны сайд хатагтай Стефани Пийкок оролцсон төдийгүй НҮБ-ийн сайд нарын чуулга уулзалтад UNWTO болон WTTC холбоодуудтай уулзалт хийснийг зохион байгуулагчдын зүгээс онцолжээ. Тус үзэсгэлэнд 180 орон, 4150 үзэсгэлэн гаргагч байсан бол 46000 оролцогчид 36074 уулзалтыг урьдчилан төлөвлөж 2,2 тэрбум орчим паундын бизнесийн хэлцэл хийсэн тооцоолол байна. Энэ нь Лондон хотын эдийн засагт 200 сая паундын орлого оруулжээ. Оролцогч байгууллагууд "GoMongolia" нэгдсэн уриан дор Азийн хэсгийн N10-620 тоот павильонд 52м2 талбайд 10 аж ахуйн нэгж болон АЖМХ-НЭЗХЭ-ийн төлөөлөл нийт 21 хүний бүрэлдэхүүнтэй амжилттай оролцов.</p> <p>Монгол улсыг төлөөлөн Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо - НЭЗХЭ болон Европ зах зээлийн салбар холбооны гишүүн дараах 10 байгууллага оролцов.</p> <p>Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Active &amp; Adventure Tours Mongolia</li> <li>2. Shine Travel</li> <li>3. Zendmen Travel</li> <li>4. Explore Mongolia</li> <li>5. Jamotoraberu</li> <li>6. Rara Avis Travel</li> <li>7. Travel On</li> <li>8. Juulchin World Tours</li> <li>9. Tsolmon Travel</li> <li>10. Great Genghis Tours &amp; Expeditions</li> </ol> <p>Дараагийн WTM-2026 үзэсгэлэн нь 2026 оны 11 дүгээр сарын 3-наас 5-ны өдрүүдэд Лондон хотын Эксел Лондон үзэсгэлэнгийн танхимд болно.</p> <p>Үйл ажиллагааны нийт дэмжлэг ССАЖЗЯ-наас 190,000,000 төгрөг байсан бол талбайн түрээс 42835 паунд, талбайн тохижилт 32000 евро, цахилгааны төлбөр 4519,32 паундын зардал тус тус гарсан. 1 байгууллагаас 3 удаагийн шилжүүлгээр 23,150,000₮ урьдчилж аван талбайн тохижилт, түрээсийн төлбөрийг бүрэн төлж барагдуулсан.</p> <p>Энэ удаагийн үзэсгэлэнгийн 1 байгууллагаас гарах зардлын хэмжээ өндөр байсан нь байгууллагуудад тун хүнд туссан бөгөөд 2025 оны 8 сарын 12-ны өдөр урьдчилгаа 70 хувь болох 133 сая төгрөг орсон бол үлдэгдэл 57 сая төгрөгний санхүүжилт 2025 оны 12 сарын 26-ны өдөр орж ирсэн.</p>	
-------	---	--	--	--	--	--	--

1.2.7	"USTOA ANNUAL CONFERENCE AND MARKETPLACE 2025" буюу АНУ-ын тур операторуудын холбооны ээлжит хуралдаан ба бизнес уулзалт	150 (санхүүжилт орж ирээгүй)	Оролцсон олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, арга хэмжээний тоо	Монголд зочлох жилийн хүрээнд олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд тогтмол оролцсон.	Монгол Улсыг гадаадад сурталчлах олон улсын 9 үзэсгэлэн, яармаг, 1-3 арга хэмжээнд оролцсон байна.	<p>Монгол Улсын Засгийн газраас 2023-2028 оныг "Монголд зочлох жил" болгон зарлах тухай Монгол Улсын Засгийн газрын 264 дүгээр тогтоол, "Монгол Улсыг гадаад орнуудад сурталчлах ажлыг нэгдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулах"; Засгийн газрын 2023 оны "Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай" 370 дугаар тогтоолын хүрээнд АНУ-ын Вашингтон хотод зохион байгуулагдсан "USTOA-2025" арга хэмжээнд төр, хувийн хэвшлийн байгууллагууд хамтран оролцов.</p> <p>Жил бүр зохион байгуулагддаг USTOA Annual Conference &amp; Marketplace нь 2025 оны 12-р сарын 1–5-нд АНУ-ын Вашингтоны ойролцоо, Maryland мужид амжилттай болж өндөрлөлөө. USTOA (АНУ-ын Тур Операторуудын Холбоо) нь 1976 онд байгуулагдсан, АНУ-ын аялал жуулчлалын салбарын хамгийн нэр хүндтэй холбоо юм. Энэхүү холбоо нь 1 сая ам.долларын аяллын баталгааны фонд бүхий, аялагчдын эрх ашгийг хамгаалдаг анхны байгууллага бөгөөд зөвхөн өндөр шалгууртай, найдвартай компаниудыг гишүүнээр элсүүлдэг бөгөөд шалгуур өндөртэй энэхүү холбоонд Монголоос "Америк Монголын аялал жуулчлалын хөгжлийн тэгш нийгэмлэг" ГҮТББ элссэн. Тус арга хэмжээнд: 800 гаруй аялал жуулчлалын удирдах түвшний мэргэжилтэн ирдэг ба 2024 онд тус холбооны гишүүдийн борлуулалтын нийт дүн \$24.4 тэрбумд хүрсэн. Уг арга хэмжээ нь гишүүн байгууллагуудтай 1:1 уулзалт (Marketplace) хийх боломж олгодог давуу талтай ба нэг компанид 11 минутын уулзалт олгогддог. Уламжлалт үзэсгэлэнгээс өөр, онцлог арга хэмжээ юм.</p> <p>Оролцогч байгууллагууд "GoMongolia" нэгдсэн уриан дор World Bazaar болон Chairman's reception хэмээх арга хэмжээнд Монголыг сурталчлан оролцсон ба Монгол улсыг төлөөлөн "Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо" болон "Америк Монголын аялал жуулчлалын хөгжлийн тэгш нийгэмлэг" ГҮТББ-ын гишүүн 5 аж ахуйн нэгжийн төлөөлөл нийт 5 хүн амжилттай оролцов. Төлөөллийг АМТА-гийн удирдах зөвлөлийн хурлаас гаргасан шийдвэрийн дагуу түрүүлж төлбөрөө хийсэн байгууллагыг сонгох зарчмаар сонгосон. Монгол улсыг төлөөлөн дараах 5 ААН оролцов. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Explore Mongolia</li> <li>2. Premium Travel Mongolia</li> <li>3. Selena Travel</li> <li>4. Travel Buddies</li> <li>5. World Summit</li> </ol> <p>Энэ удаагийн арга хэмжээнд 5 байгууллага урьдчилан гаргаж зардлыг бүрэн төлсөн ба ССАЖЗЯ-наас баталсан 150 сая төгрөгний санхүүжилтийг хүлээж байна. Дараагийн USTOA-2026 арга хэмжээ нь 2026 оны 11 дүгээр сарын 30-наас 12-р сарын 4-ний өдрүүдэд АНУ-ын Сан Франциско хотын Мариотт Маркуис зочид буудалд зохион байгуулагдана.</p> <p>Уг үзэсгэлэнгийн үр дүн маш сайн байсан ба 2026, 2027 онуудад ФАМ тур хийх, Монголын талаар вебинарыг үнэ төлбөргүй хийхээр болсон. 2026 онд өмнөх жилийнхээс олон байгууллага оролцуулж өглөөний цайны арга хэмжээн дээр Монгол улсыг сурталчлах талаар яригдаж байна.</p>
-------	--	---------------------------------	--	--	--	--

CITM (China International Travel Mart) 2025" Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн	187 (Санхүүжилт ороогүй) нийт зардал 185 сая төгрөг болсон.	Оролцсон олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, арга хэмжээний тоо	Монголд зочлох жилийн хүрээнд олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд тогтмол оролцсон.	Монгол Улсыг гадаадад сурталчлах олон улсын 9 үзэсгэлэн, яармаг, 1-3 арга хэмжээнд оролцсон байна.	<p>"CHINA INTERNATIONAL TRAVEL MART"-2025 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн 2025 оны 12 дүгээр сарын 19, 20, 21-ны өдрүүдэд БНХАУ-ын Хайнан арлын Хайкоу хотноо амжилттай болж өндөрлөлөө. CHINA INTERNATIONAL TRAVEL MART буюу CITM-2025" олон улсын үзэсгэлэнд Хятадын 31 муж, хотын захиргаа, өөртөө засах муж, Хонконг, Макао, Тайвань зэргээс гадна дэлхийн 100 гаруй орон 65000м2 талбайд оролцдог ба үзэсгэлэнгийн хүрээнд 2000 орчим В2В бизнес уулзалт зохион байгуулагдаж 50 тэрбум юаний эргэлттэй байдаг. Тус үзэсгэлэнг 300 гаруй олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчилдаг ба энэ нь 1 тэрбум гаруй үзэлтийг авчирдаг байна.</p> <p>Оролцогч байгууллагууд "GoMongolia" нэгдсэн уриан дор 1-р танхимын хэсгийн А06 тоот павильонд 68м2 талбайд АМЖХ-ны гишүүн 8 аж ахуйн нэгж болон Цагаан лавай чуулгын 5 уран бүтээлч болон АЖМХ-НЭЗХЭ-ийн төлөөлөл нийт 20 орчим хүний бүрэлдэхүүнтэй амжилттай оролцов.</p> <p>Монгол улсыг төлөөлөн Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо - НЭЗХЭ болон Хятад зах зээлийн салбар холбооны гишүүн дараах 8 байгууллага оролцов.</p> <p>Үүнд: 1. Horseback Adventure Mongolia LLC 2. Chinggis Travel Group LLC 3. ETU Travel LLC 4. Mongoltour 5. New Juulchin World LLC 6. Khishig Tour LLC 7. Golden Gobi 8. Wild Nature Travel LLC</p> <p>Дараагийн CITM-2026 үзэсгэлэн нь 2026 оны 11 дүгээр сарын 15-наас 17-ны өдрүүдэд болох төлөвлөгөөтэй байна.</p> <p>Үйл ажиллагааны нийт дэмжлэг ССАЖЗЯ-наас 187,000,000 төгрөг байсан бол талбайн түрээс, талбайн тохижилтыг 52000 ам.доллараар гэрээлэв.</p> <p>Тохижилтын төлбөрөөс 32 сая төгрөгийг оролцогч байгууллагуудаас авч урьдчилгаа хийсэн бол талбайн түрээсийн төлбөр байнга нэхэгдэж байна. Мөн үлдэгдэл тохижилтын төлбөрийг өгөхийг шаардсан мэйл өдөр бүр ирж байгаа.</p> <p>ССАЖЗЯ-наас санхүүжилт бүрэн орж ирвэл дээрх төлбөрийг даруйхан төлж барагдуулахгүй бол Монгол улсын нэр хүндэд муу нөлөө үзүүлж байна. Эдгээр байгууллагууд дараагийн удаа Монгол улстай хамтарч ажиллахгүй гэсэн байр суурьтай байгааг энд дурдах нь зүйтэй.</p>	
<b>Стратеги төлөвлөгөөний зорилго 2</b> <b>Төр хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах, төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэх, аялал жуулчлалын салбарын бүтээгдэхүүн хөгжүүлэх</b>						
<p><i>Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн үндэслэл:</i>  Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 4.2.3-д "үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.", 8.2-д "Үндэсний онцлог бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн ирээдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ."; Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 4.2.7-д "аялал жуулчлалын бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлж, улирлын хамаарлыг бууруулахад чиглэгдсэн арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх"; Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогын 4.4.9-д "аялал жуулчлалын арга хэмжээнүүдийг бүсийн хэмжээнд харилцан уялдаатай тогтоож, зохион байгуулах ажлыг тогтмолжуулах, цар хүрээг өргөжүүлэх", 4.4.14-д "шашин, соёл, спорт, адал явдалт аялал, техник, технологи, шинжлэх ухааны дэвшилтийг агуулсан улирлын хамаарал багатай аялал жуулчлалын төрөл хэлбэрийг бодлогоор дэмжих", 4.4.17-д "нутгийн ирээдэд түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийг бодлогоор дэмжиж, аялал жуулчлалд ирээдийн оролцоог нэмэгдүүлэх"; ССАЖЗЯ, АЖМХ-ны "Төрийн зарим чиг үүргийг засгийн газрын бус байгууллаагаар гүйцэтгүүлэх тухай гэрээ"-ний 2.1.1-д "Дотоодод аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх", 2.1.4-д "Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг чадавжуулах, аялал жуулчлалын салбарын оролцогчдыг сургалт, зөвлөгөө, мэдээлэл, мэргэжлийн арга зүйгээр хангах" гэж заасныг тус тус үндэслэл</p>						
<b>Зорилт 1. Аялал жуулчлалын эвент, арга хэмжээ, хөтөлбөрүүдийг (i) зохион байгуулах, (ii) дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах</b>						
					<p>Аялал жуулчлалын салбарын бүх талуудын оролцоо (төр, хувийн хэвшил, олон улсын болон олон нийтийн байгууллагууд)-г ханган, дөрвөн улирлын тогтвортой аялал жуулчлал ба бүсчилсэн хөгжлийн бодлого, төлөвлөгөөний талаар нэгдсэн ойлголт, шийдвэрт хүрч, хамтран ажиллах зорилготой "Аялал жуулчлалын долоо хоног 2025" арга хэмжээг 2024 оны 02 дүгээр сарын 10-наас 14-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулсан. Ерөнхий зохион байгуулагчаар Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо НЭЗХЭ, хамтран зохион байгуулагчаар ССАЖЗЯ ажиллав. Тус арга хэмжээний дэлгэрэнгүй тайланг ССАЖЗЯ руу хүргүүлсэн.</p>	100

Өдөр 1: Аялал жуулчлалын үндэсний чуулганд хүндэт зочноор 320 байгууллага, албан тушаалтан, хувь хүмүүсийг урихаар төлөвлөж, урилгыг биет болон цахим хэлбэрээр хүргүүлсэн. "Аялал жуулчлалын долоо хоног 2025" арга хэмжээний 5 өдрийн үйл ажиллагаанд оролцохоор нийт 963 байгууллага, хувь хүмүүс онлайнаар бүртгүүлснээс эхний өдрийн үндэсний чуулганд оролцох хүний тоо 726 байв. Чуулган зохион байгуулах Улаанбаатар зочид буудлын "Их танхим"-д 800 хүний тоогоор сандал байрлуулсан бөгөөд уригдсан болон нийт бүртгүүлсэн хүмүүсээс чуулганы нээлтэд 580 зочид ирэв. Урилгаар ирсэн хүндэт зочид болон илтгэгчдээс дурдвал, Бүгд Найрамдах Куба Улсаас Монгол Улсад суугаа элчин сайд Хорхе Феррер Родригес; Бүгд Найрамдах Итали Улсаас Монгол Улсад суугаа элчин сайд Жиованна Пиккаррета; Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсаас Монгол Улсад суугаа элчин сайд Хунгээв Сугсавад, гуравдугаар нарийн бичгийн дарга Линсумфу Суквисай; Монгол Улс дахь Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Элчин сайдын яамны дэд тэргүүн Ханна Бекер; Монгол Улс дахь Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Элчин сайдын яамны атташе Фан Зьёнг Нгуен; Монгол Улс дахь Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яамны ажилтан Paul Schaffer болон Cargol; Оросын Холбооны Улсын Эдийн засгийн хөгжлийн яамны Монгол дахь эдийн засгийн атташе Догдомэ Баир Владимирович; Япон Улсын "Mitsubishi Corporation" байгууллагын Монгол Улс дахь салбарын ерөнхий менежер Futoshi Suzuki, төлөөлөгч Keitaro Sugita; АНУ-д төвтэй "Boston Consulting Group" байгууллагын Лондон бүс хариуцсан захирал Jamie Carr; АНУ-д төвтэй "TripAdvisor" байгууллагын хамтын ажиллагаа хариуцсан захирал Rosabella Ong; АНУ-д төвтэй "ATTA (Adventure Travel Trade Association)" байгууллагын бүсийн захирал Hannah Pearson; БНСУ-ын Sejong их сургуулийн профессор Seul Ki Lee; Natural Training and Consulting АВ байгууллагын зөвлөх Jan Wigsten; ХБНГУ-ын GIZ байгууллагын хөгжлийн зөвлөх Marcus Petch нар байлаа.

Үндэсний чуулганыг батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан бөгөөд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин чуулганыг нээж үг хэлэв. Аялал жуулчлал ба бүсчилсэн хөгжил сэдвийн хүрээнд дараах гурван илтгэлийг тавив. Үүнд:

1. Аялал жуулчлалын салбарын эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэх нь Илтгэгч: Т.Баттулга /АЖМХ НЭХХЭ-ийн ерөнхийлөгч/;
2. Аялал жуулчлал ба бүсчилсэн хөгжил  
Б.Эрдэнэбаяр /"Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн" улсын төсөвт үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал, док, дэд проф/;
3. Аялал жуулчлалын бүсчлэлийн бодлого, төлөвлөлтийн шийдэл, арга зам  
Ө.Амгалан /"Хөгжлийн газарзүй судалгааны хүрээлэн" ТББ-ын тэргүүн, доктор/.

Модератор В.Ганзориг илтгэгчдийг панелистээр урьж, хэлэлцүүлгийн эхний хэсгийг зохион байгуулав. Хэлэлцүүлгийн хоёрдугаар хэсэгт ССАЖЗЯ-ны Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Болормаа, "Нью Жуулчин" ХХК-ны ерөнхий захирал Ш.Нэргүй, "Аяллын тойрог" YouTube сувгийн үүсгэн байгуулагч, аялагч Ц.Ган-Өлзий нарыг панелистээр урьж оролцуулав. Энэхүү хэлэлцүүлгээр чуулганыг өндөрлүүлж, үдээс хойш тур операторуудад зориулсан "Бизнес Аялал" арга хэмжээг зохион байгуулав. "Tourism week 2025" арга хэмжээний хүрээнд тур операторуудад зориулсан "Бизнес аялал"-ыг 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 13:00-20:00 цагт Улаанбаатар хотод үнэ төлбөргүй зохион байгуулав. Энэхүү аялалд Монгол Улсад улс руу хийх аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгч (Inbound) тур оператор компанийн төлөөлүүдийг оролцуулсан ба нийт 169 тур операторын 191 хүн оролцохоор бүртгүүлснээс 138 тур операторын 150 оролцогчдыг аялалд хамруулав. Нийт оролцогчдыг жуулчин тээврийн 45 хүний суудалтай, 4 автобусаар тээвэрлэн, төлөвлөсөн 3 өөр маршрутын дагуу бизнес аяллыг зохион байгуулав. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам Улаанбаатар хотын 4 музейг үнэгүй үзүүлэх, Нийслэлийн аялал жуулчлалын газар 2 автобусаар үнэгүй үйлчлэх, Мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбоо 2 хөтөч тайлбарлагчийг үнэгүй ажиллуулах зэргээр дэмжин ажиллав. Бизнес аяллыг гурван өөр маршрутаар зэрэг зохион байгуулсан бөгөөд Гандантэгчэнлин хийдэд зочлох болон Цагаан лавай чуулгын "Жуулчдад зориулсан урлагийн тоглолт"-ыг үзэхэд бүх оролцогчид хамт байв. Монголын бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийдэд зочлоход тэргүүн их хамба, лхаарамба Д.Жавзандорж болон Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны ерөнхийлөгч Т.Баттулга нар нийт оролцогчдоод хүндэтгэлийн үг хэлэв. Цагаан лавай чуулгын "Жуулчдад зориулсан урлагийн тоглолт"-ыг нээж ерөнхий найруулагч Д.Ганболд хүндэтгэлийн үг хэлэхийн сацуу 2025 оны тоглолтын төлөвлөгөөгөө товч танилцуулав.

2.1.1	<p>“Аялал жуулчлалын долоо хоног 2025/Tourism Week 2025” арга хэмжээ</p> <p>Аялал жуулчлалын олон улсын хөрөнгө оруулалтын чуулган</p>	300 ССАЖЗЯ 103.6 АЖМХ Нийт 403.6	<p>Зохион байгуулсан аялал жуулчлалын олон улсын болон улсын чанартай арга хэмжээ, форум, үзэсгэлэнгийн тоо</p>	<p>“Аялал жуулчлалын долоо хоног” үйл ажиллагаа нь 2дэх жилдээ зохион байгуулагдав.</p>	<p>“Аялал жуулчлалын долоо хоног 2025/Tourism Week 2025” арга хэмжээг амжилттай зохион байгуулж дуусгасан байна.</p>	<p>Өдөр 2: “Tourism Week 2025” арга хэмжээний хүрээнд 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдөр зургаан чиглэлийн салбар хуралдааныг Улаанбаатар зочид буудлын гурван танхимд зохион байгуулав. Салбар хуралдааныг зохион байгуулах ажлыг АЖМХ НЭЗХЭ-ийн Чиг үүргийн хорооны дарга нар буюу дэд ерөнхийлөгч, удирдах зөвлөлийн гишүүд хариуцан ажиллав.</p> <p>Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Зах зээлийг дэд ерөнхийлөгч В.Батзориг;</li> <li>2. Дэд бүтэц, байршуулах үйлчилгээг дэд ерөнхийлөгч О.Мөнхнасан;</li> <li>3. Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг Удирдах зөвлөлийн гишүүн Ч.Болорхүү;</li> <li>4. Маркетинг, цахим шилжилтийг Удирдах зөвлөлийн дарга Б.Золбадрал;</li> <li>5. Хууль, эрх зүй, стандартыг дэд ерөнхийлөгч Э.Тэнгисболд;</li> <li>6. Сургалт, судалгааг дэд ерөнхийлөгч Д.Батболд тус тус хариуцан ажилласан.</li> </ol> <p>Салбар хуралдаануудаас гарсан зөвлөмж, шийдвэрүүдийг нэгтгэн ССАЖЗЯ руу илгээсэн.</p> <p>Өдөр 3: “Tourism Week 2025” арга хэмжээний хүрээнд 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр Туризм Академийн сургалтуудыг Улаанбаатар зочид буудлын гурван танхимд зохион байгуулав. Туризм Академийн зорилго нь аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарын олон улсын хөгжлийн чиг хандлагад анхаарал хандуулах, орчин үеийн дэвшилтэт технологийг хэрэглээнд нэвтрүүлэх, жуулчдын сонирхлыг татсан аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагаанд суурилан бизнесийг өргөжүүлэх, дотоодын болон олон улсын бизнесийн сайн туршлагыг хуваалцах зэрэг сэдвийн хүрээнд салбарын дотоодын болон олон улсын судлаач, мэргэжилтнүүдтэй хамтарсан сургалт зохион байгуулж, хүний нөөцийг чадавхжуулахад оршино. Сургалтуудыг гурван үндсэн, зургаан дэд сэдвийн хүрээнд төрөлжүүлэн зохион байгуулав. Сургалтын танхимд техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах, хөтлөлт хийх, илтгэгч багш нарыг танилцуулах, сургалтыг хөтөлбөрийн дагуу явуулах, оролцогчдод дэмжлэг үзүүлэх зэрэг туслах ажил дээр JCI Монгол академийн 10 туслах багш нар хамтран ажилласан. Гадаад улсын таван багш, экспертүүдийг урьж оролцуулав. АЖМХ НЭЗХЭ нь дараах хоёр байгууллагатай “Хамтын ажиллагааны санамж бичиг”-т гарын үсэг зурав. Үүнд: Монгол Улсын Гадаад харилцааны яамны харьяа “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” Төрийн өмчит үйлдвэрийн газар</p> <p>БНСУ-ын Сэжон их сургуулийн Tourism lindustry Data Aanalytics Lab (TIDAL)</p>	
-------	--	--	---	---	--	---	--

<p>Өдөр 4: "Tourism Week 2025" арга хэмжээний хүрээнд 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Бизнес хамтын ажиллагааны өдөрлөг буюу B2B бизнес уулзалтыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын их танхимд зохион байгуулав. Тус үйл ажиллагаанд 106 байгууллага (зочид буудал, жуулчны бааз, гэст хаус, хостел г.м.) оролцохоор бүртгүүлснээс 93 байгууллага хүрэлцэн ирж бүтээгдэхүүн, үйлчилгээгээ танилцуулж, тур операторуудтай гэрээ байгуулав. Оролцохоор бүртгүүлсэн 106 байгууллагыг үйл ажиллагааны чиглэлээр нь ангилж харуулбал:</p> <p>Оролцохоор бүртгүүлсэн байгууллагуудыг үйл ажиллагааны чиглэлээр ангилбал:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Зочид буудал – 7</li> <li>2. Жуулчны бааз – 51</li> <li>3. Амралтын газар – 5</li> <li>4. Резорт, лодж – 12</li> <li>5. Гэст хаус – 7</li> <li>6. Ресторан – 3</li> <li>7. Ханган нийлүүлэгч байгууллага – 14</li> <li>8. Бусад байгууллага – 7</li> </ol> <p>Оролцохоор бүртгүүлсэн байгууллагуудын байршуулах хэрэгслийг байршлаар нь ангилж харуулбал:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Архангай – 17</li> <li>2. Булган – 3</li> <li>3. Говьсүмбэр – 2</li> <li>4. Дорноговь – 2</li> <li>5. Өвөрхангай – 4</li> <li>6. Өмнөговь – 5</li> <li>7. Төв – 23</li> <li>8. УБ, Налайх дүүрэг (Тэрэлж) – 9</li> <li>9. УБ, бусад дүүргүүд – 33</li> <li>10. Увс – 1</li> <li>11. Хөвсгөл – 7</li> </ol> <p>Их танхим руу орох хэсгийн талбайд байрлуулсан зургаан бүүтэд ханган нийлүүлэгч дараах байгууллагууд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ танилцуулав. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Амар даатгал ХХК</li> <li>2. Глобал пилларс ХХК</li> <li>3. Гүрмэ ХХК</li> <li>4. Жи ти ди эм ХХК</li> <li>5. МСК кашмер</li> <li>6. Торгоны зам ХХК</li> </ol> <p>Уулзалтад ирсэн оролцогчдод ойлгомжтой байлгах зорилгоор орох хэсэгт 1,5x1,5 метрийн хэмжээтэй, ширээний дугаар, байршлыг харуулсан план зургийг байрлуулсан. Бизнес хамтын ажиллагааны өдөрлөгийг сонирхох, оролцогч байгууллагуудтай уулзах, танилцах, гэрээ байгуулах зорилготой 66 тур оператор, 14 жуулчны бааз /ширээ авч чадаагүй газрууд/, 50 гаруй бусад байгууллага болон хувь хүмүүс хүрэлцэн ирсэн. Оролцогч нэг байгууллага ойролцоогоор 40-80 хувь хүн болон байгууллагуудад мэдээлэл өгч, 15-50 гэрээ байгуулав. Хөтөлбөрийн дагуу нийт 5 илтгэл, танилцуулга тайзан дээр тавигдсан бөгөөд 20 орчим байгууллагын шторк, рекламьг 2-3 давталттайгаар их танхимд үзүүлэв. АЖМХ НЭЗХЭ-ийн Хятад зах зээлийн салбар холбоо нь Улаанбаатар хотын Хятадын Соёлын төвтэй "Хамтын ажиллагааны санамж бичиг"-т гарын үсэг зурав.</p>	
<p>Өдөр 5: "Tourism Week 2025" арга хэмжээний хүрээнд 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр Аялал жуулчлалын оюутан, залуучуудын өдөрлөгийг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын их танхимд зохион байгуулав. Тус өдөрлөгт аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарын мэргэжлийн хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг 16 их, дээд болон мэргэжлийн боловсролын сургуулийн 400 орчим оюутнууд багш нарын хамт оролцов. Аялал жуулчлалын салбарын оюутнуудыг мэргэжлээрээ бахархах, мэргэжилдээ дурлан суралцах идэвхийг нь өдөөх, аялал жуулчлалын салбарын ирээдүйн чиг хандлага, боломжуудын талаар тайлбарлан ойлгуулах зорилготой хоёр илтгэл, нэг ярилцлагыг зохион байгуулав. Аялал жуулчлалын оюутны нэгдсэн холбооноос салбарын оюутнуудыг хооронд нь танилцуулах, багийн ажиллагааг хөгжүүлэх зорилготой хөгжөөнт тоглоом, уралдааныг зохион байгууллаа.</p>	

2.1.2	Түмэн тэмээний баяр 2025	30	Өмнөговь аймагт улалмжлал болгон зохион байгуулдаг бөгөөд 27 дахь жилдээ болж байна.	Аялал жуулчлалын дотоодын эвентүүдийг дэмжин зохион байгуулах	Монгол Улсын Аялал жуулчлалын нэгдсэн цагалбарт тусгагдсан 11 эвент үйл ажиллагааг ССАЖЗЯ, АЖМХ - ны Төрийн зарим чиг үүргийг засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай ССАЖЗЯ 25 22 дугаартай гэрээ, А50 дугаар тушаалыг үндэслэв.	<p>"Түмэн тэмээний баяр - 2025" Өвлийн аялал жуулчлалын эвент 2025.02.01 -ны өдрөөс 2025.02.03 -ны хооронд Өмнөговь аймгийн Даланзадгад суманд говийн аймгуудын тэмээнд түшиглэсэн соёл, уламжлалыг түгээн дэлгэрүүлэх, тэмээн аялал, тэмээн спортыг хөгжүүлэх, тэмээчид малчдаа алдаршуулах, тэмээн сүргийг өсгөн хамгаалах, аялал жуулчлал хөгжүүлж орон нутгийн хөгжлийг дэмжих үндсэн зорилготойгоор зохион байгуулагдсан.1997 оноос анхлан зохион байгуулагдсан "Түмэн тэмээний баяр" өвлийн наадам нь 2016 онд Монгол орны тэмээчид, уралдаанчдыг хамарсан "Монгол тэмээ-999" тэмээний уралдаанд 1108 тэмээ барианд оруулж Гиннесийн дээд амжилтыг шинэчлэн тогтоож байсан бөгөөд улалмжлал болгон зохион байгуулагдаад 27 дахь жилдээ болж байна.</p> <p>Оролцогч:  "Түмэн тэмээний баярт Өмнөговь, Дорноговь, Дундговь, Баянхонгор, Ховд, Хөвсгөл зэрэг аймгийн 21 сумаас 24 500 гаруй оролцогч, гадаадын 10 гаруй улс орны 100 гаруй мэргэжилтэн, аялагч жуулчид оролцжээ. Мөн таван аймгийн бизнес эрхлэгч 120 гаруй иргэн, 50 гаруй аж ахуйн нэгж худалдаа үйлчилгээ үзүүлсэн байна.</p> <p>Дүгнэлт:  1. Улсын хэмжээнд Өвлийн аялал жуулчлалыг уртасган дэмжих хамгийн том өвлийн арга хэмжээ бөгөөд Тэмээний амьдын үнэлэмжийг 2дахин нэмэгдэглүүлэн, тэмээчин ардын хөдөлмөрийг үнэлэн улсаас цол тэмдэг олгодог болсон. 2. Дэлхийн тэмээн холбоонд албан ёсны гишүүн орон болох урилга ирэн Монгол улсын Тэмээний баяр, тэмээг хайрлан өсгөж, үржүүлж буй туршлагыг олон улсад таниулан сурталчлах ёстой хэмээн дүгнэсэн. 3. Жил ирэх бүр Тэмээний баярыг сонирхон оролцох дотоод, гадаадын зочдын тоо, оролцогч тэмээчдийн тоо өссөөр байгаад баяртай байна.4. Монголын тэмээний тогтворвой хөгжлийн боломж хэлэлцүүлэгт орон нутгийн иргэд, Монгол, Авсирали, Арабын эрлэмтэн судлаачид оролцсон.</p>	
-------	--------------------------	----	--	---	---	--	--

2.1.3	Талын түмэн адуу 2025	20	Талын түмэн 11 дахь удаагийн	Аялал жуулчлалын дотоодын эвентүүдийг дэмжин зохион байгуулах	<p>Монгол Улсын Аялал жуулчлалын нэгдсэн цагалбарт тусгагдсан 11 эвент үйл ажиллагааг ССАЖЗЯ, АЖМХ - ны Төрийн зарим чиг үүргийг засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай ССАЖЗЯ[25]22 дугаартай гэрээ, А50 дугаар тушаалыг үнлэслэв.</p>	<p>Монгол Улсын Засгийн газраас “Түүхэн болон төрөлжсөн аялал жуулчлалыг хөгжүүлэх” зорилтын хүрээнд зүүн бүсийг түүхэн аялал жуулчлалын бүс нутаг болгон зарласантай холбогдуулан өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгын дор Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас Монголын уламжлалт ёс заншил, адуу дагасан соёлын биет болон биет бус өвийг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх зорилготойгоор Талын Түмэн Адуу арга хэмжээг 11 дахь удаагаа өргөн цар хүрээг хамруулан Монголчуудын уламжлалт соёлын өв, нүүдэлчин ахуй амьдралын салшгүй хэлхээ болох адуу дагасан соёлыг түгээн дэлгэрүүлж, үр хойч, залуу үедээ сурталчлан өвлүүлэх, нутгийн иргэдэд түшиглэсэн, тогтвортой, хариуцлагатай аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилготойгоор амжилттай зохион байгуулагдлаа. Арга хэмжээний хөтөлбөрийг англи, монгол бичиг болон өдөр өдрөөр нь салгасан байдлаар Монгол хэлээр бэлтгэж түгээсэн нь хүмүүст их таалагдаж байсан. Нээлтийг Төрийн их тулгыг тахин цэнгүүлж, Эзэн богд Чингис хаан гал голомтдоо заларч үр хүүхэд, хойч үедээ алтан сургаалаа айлдаж буй мэтээр дүрслэн илэрхийлсэн ба 30 морьтон цэрэг, адуучин эрсийн морьт жагсаал, Монголчуудын ан агнуурын гол уламжлал болох Монгол анч тайга нохой зэрэг нүүдэлчдийн сүр хүчийг харуулсан жагсаал зохион байгуулж, АДБ-ийн Хан Хэнтий чуулгын 30 гаруй уран бүтээлчид МУ-ын УГЗ, Хөдөлмөрийн баатар, тэргүүн зэргийн Чингис хаан одонт хөгжмийн зохиолч Б.Шаравын “ Чингис хаан” дуулалт жүжгийн зургадугаар үзэгдлийн “Чингис хаан”-ны хэсгээс толилуулсан.</p> <p>Мөн эвентийн үеэр гадна, дотны жуулчдад зориулж 11 дүгээр сарын 22,23-ны өдрүүдэд АДБ-ийн Хан Хэнтий чуулгын уран бүтээлчдийн “Сэцэн ханы дуулал”, “Сэрсэн тал” тоглолтууд тоглогдож нийт 900 гаруй үзэгчдэд Монголынхоо сонгодог бүтээлүүдийг хүргэсэн байна.</p> <p>Оролцогч: Талын нүүдэлчин, малчдын мал маллах арга ухаан, ялангуяа адуу маллах арга ухаан, түүнийг дагасан соёлын биет болон биет бус өвийг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх зорилготой “Талын түмэн адуу” 11 дахь удаагийн эвент нь дотоодын 20,000 гадаадын 24 орны 150 орчим зочин, оролцогчдыг татан, өвлийн хүйтэн өдрүүдийг халуун дурсамжаар дүүрэн болгосон юм.</p> <p>Дүгнэлт: Жил бүрийн уламжлал болсон энэхүү фестиваль нь адуу дагасан соёлыг хамгаалах сурталчлах зорилготой бөгөөд Монгол орны 18 аймгаас адуу сонирхогч, уран бүтээлчид, оролцогчид хуран чуулдагаараа онцлогтой. Монгол үндэсний хувцас, тоноглол, морины зураг будах ажлуудыг зохион байгуулж дээрх эвентийн хүрээнд Музейн боловсролын ажилд хүүхэд 242, насанд хүрэгч 119, гадаадын жуулчин 34 хүнд хүрч монгол ард түмний олон мянган жилийн оюун санааны хосгүй үнэт өвийг түгээн дэлгэрүүлэн ажилласан.</p>	100%
-------	-----------------------	----	---------------------------------	---	--	--	------

2.1.4	Айс фестивал 2025	20	"KARAKORUM ICE FESTIVAL" нь 13 дахь удаагаа амжилттай зохион байгуулагдлаа.	Аялал жуулчлалын дотоодын эвентүүдийг дэмжин зохион байгуулах	Монгол Улсын Аялал жуулчлалын нэгдсэн цагалбарт тусгагдсан 11 эвент үйл ажиллагааг ССАЖЗЯ, АЖМХ - ны Төрийн зарим чиг үүргийг засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай ССАЖЗЯ 25 22 дугаартай гэрээ, А50 дугаар тушаалыг үнлэслэв.	<p>2025 оны "KARAKORUM ICE FESTIVAL" нь Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Улаанцутгалангийн хүрхрээнд уламжлалт ёсоор 13 дахь удаагаа амжилттай зохион байгуулагдлаа. Арга хэмжээ амралтын өдрүүдтэй давхцсан нь оролцогч, үзэгч, жуулчдын тоог нэмэгдүүлж, фестивалийн уур амьсгалыг өмнөх жилүүдээс илүү өргөн цар хүрээтэй, олон талт болгосон.</p> <p>Энэ жилийн фестиваль нь зөвхөн спортын тэмцээнээр хязгаарлагдаж, өв соёл, нүүдэлчин уламжлал, нутгийн иргэдийн оролцоог нэг дор төвлөрүүлсэн цогц арга хэмжээ болон өргөжсөн нь онцлох дэвшил байв.</p> <p>Оролцогчдын хувьд фестивалийн үйл ажиллагаанд оролцсон хүмүүсийн бүтэц нь бүс нутгийн аялал жуулчлалын идэвхжил болон спортын арга хэмжээний өсөлтийг тодорхой харуулсан бөгөөд нийт оролцогчдын тоо 800 гаруйд хүрсэн байна.</p> <p>Дүгнэлт: "Karakorum Ice Festival"-ийн хөгжлийн замнал нь Монголын өвлийн спорт, уулын соёлын түүхэнд чухал байр суурь эзэлдэг. Тухайлбал:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. 2012 онд "Ice Challenge" нэртэйгээр анхны санаачилга эхэлсэн. Санаачлагчид нь С. Алдархишиг, МУГТ, ОУХМ Г. Өсөхбаяр нар байв.</li> <li>2. 2015 онд "Сутайн Бор" клубын оролцоотойгоор Улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулагдсан.</li> <li>3. 2019 онд "Karakorum Ice Festival" нэршилтэй болж, цар хүрээгээ тэлсэн.</li> </ol> <p>Мөн 2022 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Шинэ Хархорум хотыг сэргээн байгуулах зарлиг гарсан нь Хархорум хотын нэрээр нэрлэгдсэн уг фестивалийн цаашдын хөгжилд эерэг нөлөө үзүүлж, бүс нутаг болон дэлхийн мөсөн авирагчдыг татах, Монголын өвлийн аялал жуулчлалыг олон улсын түвшинд гаргах стратегийн боломжийг нэмэгдүүлж байна.</p> <p>Сүүлийн жилүүдэд фестивалийн орчинтой холбоотой дэд бүтцийн хөгжил мэдэгдэхүйц ахицтай байна. Гол сайжруулалтууд нь:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Бат-Өлзий–Хужирт чиглэлийн шинэ 50 км хатуу хучилттай зам ашиглалтад орсон</li> <li>2. Цахилгаан шугамын шинэчлэл хийгдсэн</li> <li>3. Жуулчны баазуудын тоо, багтаамж, үйлчилгээний чанар нэмэгдсэн</li> <li>4. Төрийн байгууллагуудын оролцоо илүү бодитой, идэвхтэй болсон</li> </ol> <p>Эдгээр өөрчлөлт нь цаашдын аялал жуулчлалын урсгалыг нэмэгдүүлэх, фестивалийг олон улсын түвшинд тогтвортой хөгжүүлэх суурь нөхцөл болж байна.</p>	100%
-------	-------------------	----	---	---	---	---	------

2.1.5	Бүргэдийн баяр 2025	20	2025 оны 10 дугаар сарын 3-5 ны өдөр, Буянт сумын нутаг Шар нуурын "Хойлог толгой" -д зохион байгуулагдсан.	Аялал жуулчлалын дотоодын эвентүүдийг дэмжин зохион байгуулах	Монгол Улсын Аялал жуулчлалын нэгдсэн цагалбарт тусгагдсан 11 эвент үйл ажиллагааг ССАЖЗЯ, АЖМХ -ны Төрийн зарим чиг үүргийг засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай ССАЖЗЯ 25 22 дугаартай гэрээ, А50 дугаар тушаалыг үнлэслэв.	<p>2025 оны 10 дугаар сарын 3-5-ны өдрүүдэд Буянт сумын нутаг, Шар нуурын "Хойлог толгой" хэмээх газарт уламжлалт Бүргэдийн баярын баяжуулсан хөтөлбөрийн дагуу "Шувуулахуйн гайхамшиг – 2025" арга хэмжээг зохион байгуулав.</p> <p>Арга хэмжээний нээлтийг тусгайлан зассан тайзан дээрээс казах, монгол, англи хэлээр танилцуулж, сурталчилан удирдлагуудын оролцоотойгоор зохион байгуулсан. Нээлтийн үйл ажиллагаанд Баян-Өлгий аймгийн Засаг дарга С. Зангар, "Казах шувуулахуйн холбоо" ТББ-ын тэргүүн, Сагсай сумын Засаг дарга Б. Бекболат, "Номадик экспедишнс" ХХК-ийн үүсгэн байгуулагч, ерөнхий захирал Жалсаа Урубшуров, аймгийн Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч. Өлзийтунгалаг, "Казах шувуулахуйн холбоо" ТББ-ын гүйцэтгэх захирал А. Атай нар оролцов.</p> <p>Зохион байгуулагчдын шийдвэрээр энэ удаагийн арга хэмжээнд зөвхөн эм бүргэд буюу эх шувуу нисгэж үзүүлсэн. Бүргэдчдийн нэгдсэн жагсаал болон арга хэмжээнд Баян-Өлгий аймгийн Өлгий, Алтай, Алтанцөгц, Бугат, Буянт, Дэлүүн, Толбо, Сагсай, Улаанхус сумын нийт 75 бүргэдчин оролцов. Хамгийн өндөр настай бүргэдчнээр Өлгий сумын 12 дугаар багийн бүргэдчин, МУСТА А. Тургынбек, хамгийн бага насны бүргэдчнээр Сагсай сумын 9 настай бүргэдчин Б. Динислам оролцсон байна. Мөн Өлгий, Сагсай, Улаанхус сумаас 3 эмэгтэй бүргэдчин оролцож, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн. Бүргэдчдийн оролцоо, хандлага өмнөх жилүүдээс буураагүй бөгөөд энэхүү өв соёлыг өвлөн авч буй 9-12 насны 6 охид, хөвгүүд өөрсдийн морь, зориулалтын хувцас, анчин бүргэдтэйгээ ирж оролцсон нь гадаад, дотоодын жуулчид, үзэгчдийн анхаарлыг татаж, талархлыг хүлээсэн.</p> <p>Спорт, уламжлалт үзүүлбэрийн хүрээнд дараах арга хэмжээнүүд зохион байгуулагдав. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Аймгийн Хөгжимт драмын театрын жүжигчдийн хэсэгчилсэн тоглолт</li> <li>2. Төгс бүргэдчин шалгаруулах нээлттэй арга хэмжээ</li> <li>3. Бүргэд гар дээр дуудах үзүүлбэр</li> <li>4. Бүргэд чаргайд буулгах үзүүлбэр</li> <li>5. Казах үндэсний "Айтыс" харилцаа дууны үзүүлбэр</li> <li>6. Жороо морьдын уралдаан</li> <li>7. Ямааны тулам булаалдах тэмцээн /көкпар/</li> <li>8. Казах үндэсний "Асык ату" буюу "Шувуулахуй", монгол үндэсний шагайн харвааны тэмцээн</li> <li>9. Кыз куарчдын үзүүлбэр</li> <li>10. Газар дээрээс мөнгө шүүрэх үзүүлбэр</li> <li>11. Эрэгтэй, эмэгтэй, хүүхдийн дунд халх, урианхай сурын харваа</li> </ol> <p>Урлаг, соёлын арга хэмжээний хүрээнд баярын талбай дээр аймгийн Хөгжимт драмын театрын жүжигчид Бүргэдийн баярт зориулсан тусгай хөтөлбөрийн хүрээнд 1 цагийн концерт тоглосон. Мөн казах үндэстний ардын дуу хөгжим, язгуур урлаг, биелгээ болон бусад төрөлжсөн номер бүхий тоглолт нь гадаад, дотоодын жуулчид, оролцогчдын сонирхлыг татсан үзүүлбэр боллоо.</p> <p>Бүргэдийн баяр нь өөрийн зорилго, зорилтод нийцсэн өргөн дэлгэр арга хэмжээ болж өнгөрсөн. Баярын үндсэн үзүүлбэрүүд болох бүргэд гар дээр дуудах, бүргэд чаргайд буулгах төрлүүдэд нийт 103 бүргэдчин өрсөлдөж, бүргэдийн уяа сойлго, бүргэдчний авхаалж самбааг сорьсон, үзэгчдийн сонирхлыг татсан томоохон арга хэмжээ болсныг тэмдэглэх нь зүйтэй.</p>	100%
-------	---------------------	----	---	---	--	--	------

2.1.6	APA фестиваль 2025	20	Архангай аймагт 2 дахь жилдээ зохион байгуулагдаж байгаа.	Аялал жуулчлалын дотоодын эвентүүдийг дэмжин зохион байгуулах	Монгол Улсын Аялал жуулчлалын нэгдсэн цагалбарт тусгагдсан 11 эвент үйл ажиллагааг ССАЖЗЯ, АЖМХ - ны Төрийн зарим чиг үүргийг засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай ССАЖЗЯ 25 22 дугаартай гэрээ, А50 дугаар тушаалыг үнлэслэв.	<p>Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болох "Алсын хараа-2050", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд хэрэгжиж буй хот, хөдөөгийн сэргэлтийн зорилтыг дэмжих, хөгжлийн тэнцвэрийг хангах зорилгоор Засгийн газраас 2025 оныг "Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил" болгон зарласан.</p> <p>Энэхүү бодлогын хүрээнд Хангайн бүсийг аялал жуулчлалын гол төв болгон хөгжүүлэх зорилгоор Архангай аймагт "ARA FEST 2024" наадмыг нэг сарын хугацаанд амжилттай зохион байгуулсан. Харин 2025 онд тус фестиваль гурав дахь жилдээ арга хэмжээний цар хүрээ, дэд бүтцийн хувьд өргөжин тэлж, спортын олон улсын болон улсын аварга шалгаруулах тэмцээнүүдийг зохион байгуулахаар бэлтгэл ажлаа эхлүүлээд байна.</p> <p>"ARA Complex" нь 2025 оны зургаадугаар сараас наймдугаар сар хүртэл урлаг, спорт, шашин, соёлын чиглэлийн олон төрлийн арга хэмжээг олон улсын оролцоотой зохион байгуулж, дотоод, гадаадын нийт 400 мянга орчим зочны урсгалыг татах зорилт тавин ажиллажээ. Дүгнэлт: "ARA FEST 2025" нь зөвхөн томоохон хөтөлбөрүүдээр хязгаарлагдахгүй, наадмын талбайд байрлах "ARA Complex"-ийн хүрээнд ирсэн зочин бүрд өдөр бүр нээлттэй олон төрлийн нэмэлт хөтөлбөр, үйлчилгээг санал болгож буйгаараа онцлог байв. Зочид үндсэн хөтөлбөрүүдийн завсар болон хүссэн үедээ авто спортын наадам болох дрифт, драг, ралли, оффроадын үзүүлбэрүүдийг үзэхийн зэрэгцээ дараах адал явдалт үйл ажиллагаанд оролцох боломжтой байлаа. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. "ARA Цамхаг"-т гарч, өндрөөс буух зиплайн болон "Солонгон гулсуур"-аар гулгах</li> <li>2. Найз нөхдөрөө пэинтбол тоглож, багаараа өрсөлдөх</li> <li>3. 100 монгол гэр бүхий "Гэр кэмп" болон орчин үеийн унтлагын капсулд байрлан тав тухтай амрах</li> </ol> <p>Эдгээр дэд бүтэц, нэмэлт хөтөлбөрүүд нь наадмыг амралт, зугаалгын цогц орчин болгон бүрдүүлж, оролцогчдын тав тухыг хангах зорилгоор орчин үеийн стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжийг шинээр ашиглалтад оруулсан байна.</p>	100%
-------	--------------------	----	---	---	---	--	------

2.1.7	Айраг фестивал 2025	10	2008 оноос эхлэн 16 дахь жилдээ зохион байгуулагдаж байна.	Аялал жуулчлалын дотоодын эвентүүдийг дэмжин зохион байгуулах	Монгол Улсын Аялал жуулчлалын нэгдсэн цагалбарт тусгагдсан 11 эвент үйл ажиллагааг ССАЖЗЯ, АЖМХ - ны Төрийн зарим чиг үүргийг засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай ССАЖЗЯ 25 22 дугаартай гэрээ, А50 дугаар тушаалыг үнлэслэв.	<p>Монголчуудын уламжлалт өв соёл, мэдлэг арга ухааныг дэлгэрүүлэх, уламжлалт баяр наадам, ёс, зан үйл, тоглоом наадгай, хөхүүрт айраг исгэж хэрэглэдэг уламжлалыг дэлгэрүүлэх замаар "Айраг фестиваль" эвентийг 2008 оноос эхлэн 16 дахь удаа, Юнескогийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтад 2019 онд бүртгэгдсэнээр 5 дахь удаагаа Булган аймгийн Булган сумын 6 дугаар багийн нутаг дэвсгэр, морь барианы газарт 2025 оны 08 дугаар сарын 08, 09-ний өдрүүдэд зохион байгууллаа.</p> <p>Дүгнэлт: Айраг адууны соёл бол бидний соёлын үнэт өвийн нэг бөгөөд бид энэхүү соёлын өв уламжлалаа хамгаалж, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон сурталчилж эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх өргөн нөөц боломж байна. Энэ жилийн хувьд 16 сум нэгдсэн журмаар гэрээ барьж орон нутгийн онцлогоо сурталчлан оролцсон нь наадмыг сурталчлах, наадамчдад эерэг сэтгэгдэл үлдээх зэрэг давуу талууд бий болгосон. Үндсэн зураглалын дагуу нийт талбайн зохион байгуулалтын хувьд эмх цэгцтэй өнгө үзэмжтэй өмнөх жилүүдийн наадмаас илүү байсан. Мөн "Айраг фестивалийн" төв тайзыг тогтмол үйл ажиллагаатай байлгаж хуваарийн дагуу сонирхолтой хэлбэрээр зохион байгуулсан нь үзэж сонирхохоор ирсэн наадамчин олонд эерэг сэтгэгдэл төрүүлж төв тайз байнгын үзэгчтэй байлаа.</p> <p>Цаашид анхаарах асуудал:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Хүүхэд, залуус соёлын биет бус өвийг цаашид хамгаалах, өвлөн уламжлах, суралцах зэрэг оюуны соёлын дархлаа бий болох боломж бүрдсэн хөтөлбөр бэлтгэх.</li> <li>2. Айраг фестивалийн үр ашиг үйлдвэр эрхлэгчдийн нийт орлогыг олон нийтэд сурталчилан таниулах, тэдний оролцоог цаашид нэмэгдүүлэх</li> <li>3. Хоолны худалдаа эрхлэгчдийн өнгө үзэмжид анхаарч нэг стандартад нэгтгэж, нэгдсэн зохион байгуулалтад оруулах</li> <li>4. Айраг фестивалийн ажлын хэсгийг эрт байгуулж, нэгдсэн төлөвлөлтийг эртнээс бэлтгэн гаргаж ард иргэд гадаад дотоодын аялагч амрагчдын төлөвлөлтөд оруулж хэвших /төсвөөс шалтгаалан маш их удааширдаг/</li> <li>5. Аймгийн хэмжээнд ажиллаж байгаа нийт төрийн албан хаагчдаас Цагдаагийн байгууллагад тусгайлан хоол унааны зардал шийдвэрлэдэг нь төсөвт хүндрэл учруулдаг.</li> <li>6. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр Айраг фестивалийг сурталчлан таниулах, үр дүн цар хүрээг нэмэгдүүлэх</li> <li>7. Цаашид Айраг фестивалийн зохион байгуулж байгаа газрыг тогтмолжуулж тусгай хэрэгцээнд авах, тухайн газартаа наадамтай холбоотой бүтээн байгуулалтыг хийх. /төв хаалга, морины уяа, тусгаарлах шон, гэрийн буйр гэх мэт/</li> </ol>	100%
2.1.8	Монгол туургатны харвуул их наадам	10		Аялал жуулчлалын дотоодын эвентүүдийг дэмжин зохион байгуулах	Монгол Улсын Аялал жуулчлалын нэгдсэн цагалбарт тусгагдсан 11 эвент үйл ажиллагааг ССАЖЗЯ, АЖМХ - ны Төрийн зарим чиг үүргийг засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай ССАЖЗЯ 25 22 дугаартай гэрээ, А50 дугаар тушаалыг үнлэслэв.	Төсөв батлагдсан боловч эвент зохион байгуулагдаагүй тул ССАЖЗЯамруу буцаахаар тооцоо нийлэв.	0%

2.1.9	Цайны зам соёлын өвийн наадам	10		Аялал жуулчлалын дотоодын эвентүүдийг дэмжин зохион байгуулах	Монгол Улсын Аялал жуулчлалын нэгдсэн цагалбарт тусгагдсан 11 эвент үйл ажиллагааг ССАЖЗЯ, АЖМХ - ны Төрийн зарим чиг үүргийг засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай ССАЖЗЯ 25 22 дугаартай гэрээ, А50 дугаар тушаалыг үнлэслэв.	Төсөв батлагдсан боловч эвент зохион байгуулагдаагүй тул ССАЖЗЯамруу буцаахаар тооцоо нийлэв.	0%
2.1.10	Дарьганга фестиваль	10		Аялал жуулчлалын дотоодын эвентүүдийг дэмжин зохион байгуулах	Монгол Улсын Аялал жуулчлалын нэгдсэн цагалбарт тусгагдсан 11 эвент үйл ажиллагааг ССАЖЗЯ, АЖМХ - ны Төрийн зарим чиг үүргийг засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай ССАЖЗЯ 25 22 дугаартай гэрээ, А50 дугаар тушаалыг үнлэслэв.	Төсөв батлагдсан боловч эвент зохион байгуулагдаагүй тул ССАЖЗЯамруу буцаахаар тооцоо нийлэв.	0%
2.1.11	One day of Mongolia Аялал жуулчлалын гэрэл зургийн эвент	10		Аялал жуулчлалын дотоодын эвентүүдийг дэмжин зохион байгуулах	Монгол Улсын Аялал жуулчлалын нэгдсэн цагалбарт тусгагдсан 11 эвент үйл ажиллагааг ССАЖЗЯ, АЖМХ - ны Төрийн зарим чиг үүргийг засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай ССАЖЗЯ 25 22 дугаартай гэрээ, А50 дугаар тушаалыг үнлэслэв.	Төсөв батлагдсан боловч эвент зохион байгуулагдаагүй тул ССАЖЗЯамруу буцаахаар тооцоо нийлэв.	0%

2.1.12	Жангар тууль хайлах наадам	10		Аялал жуулчлалын дотоодын эвентүүдийг дэмжин зохион байгуулах	Монгол Улсын Аялал жуулчлалын нэгдсэн цагалбарт тусгагдсан 11 эвент үйл ажиллагааг ССАЖЗЯ, АЖМХ - ны Төрийн зарим чиг үүргийг засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай ССАЖЗЯ 25 22 дугаартай гэрээ, А50 дугаар тушаалыг үнлэслэв.	Төсөв батлагдсан боловч эвент зохион байгуулагдаагүй тул ССАЖЗЯамруу буцаахаар тооцоо нийлэв.	0%
2.1.13	Хямд амар өвлийн аялал жуулчлалыг дэмжих цахим экспо	(20 санхүүжилт олгогдоогүй)				Төсвийн тодотголоор төсөв татагдан тушаал гараагүй. Эвент зохион байгуулагдаагүй.	0%
2.1.14	контент	(160 Төсөв татагдсан)				Төсвийн тодотголоор төсөв татагдан тушаал гараагүй. Эвент зохион байгуулагдаагүй.	0%

2.1.15	Адалт явдалт аялал жуулчлалыг Монгол Улсад хөгжүүлэх чиглэлээр хийж буй ажлуудаас	200 (төсөв татагдсан)	АТТА (АНУ-д төвтэй Адал явдалт аялал жуулчлалын холбоо)-той хамтран зохион байгуулсан сургалтын тоо		АТТА-тай хамтран ажиллаж, Үндэсний сургагч багш нарыг бэлтгэсэн байна.	<p>АТТА-тай хийсэн уулзалтын тэмдэглэл</p> <p>Огноо: 2025.03.06 Байршил: Мессэ Бэрлин үзэсгэлэнгийн танхим, 26-р танхим, 301 павильон</p> <p>Оролцогчид: АТТА: Густаво Тимо, Дэд Ерөнхийлөгч, Ханна Пирсон, Бүс хариуцсан захирал МТО: М.Нарангэрэл, Гүйцэтгэх захирал, Ш.Анхбаяр, Гадаад харилцааны менежер</p> <p>Уулзалтаар АТТА-гийн AdventureEDU сургалтын хөтөлбөрийн хүрээнд "Adventure Guide Training" болон "Train-the-Trainer" сургалтын талаар дэлгэрэнгүй ярилцав. Сургалтын зорилго, бүтэц, хэрэгжүүлэх хугацаа, хамрах хүрээ болон МТО-гийн хэрэгцээ шаардлагад хэрхэн нийцүүлэх талаар санал солилцсон.</p> <p>"Adventure Guide Training" сургалтын зардал 36,000 ам.доллар, 5 өдрийн хугацаатай, 25 оролцогч, 2 багштай байхаар танилцуулсан. "Train-the-Trainer" сургалтын зардал 42,000 ам.доллар, 7 өдрийн хугацаатай, 2 багштай байна. Дээрх төсөвт байр, хоол, нислэгийн зардал багтаагүй бөгөөд бэлтгэл ажлын хугацаа тус тус 6 сар, 3 сар байхаар дурдагдав.</p> <p>МТО-гийн зүгээс сургалтын хэрэгцээ, хамрагдах боломжтой оролцогчдын талаар нарийвчлан судлах, АТТА-тай гэрээ байгуулах процесс болон санхүүжилтийн боломжит хувилбаруудыг хэлэлцэх, хэрэгжилтийн төлөвлөгөө болон зохион байгуулалтын асуудлыг тодорхой болгохоор тохиролцов.</p> <p>Уулзалтаар Adventure Week in Mongolia төслийн ойролцоох зардал 150,000 ам.доллар байсныг хэлэлцээрийн үр дүнд 80,000 ам.доллар хүртэл бууруулах боломжтой болсон. Уг зардлыг 2 хувааж төлөхөөр ярилцсан бөгөөд 50 хувийг нь төсөл эхлэхээс 6 сарын өмнө, үлдсэн 50 хувийг 2026 оны 01 дүгээр сард төлөх боломжтой гэж үзсэн.</p> <p>Сургалтыг 09–10 дугаар саруудад зохион байгуулах боломжтой. Гэхдээ Train-the-Trainer сургалтад хамрагдахын тулд Adventure Guide Training сургалтад дор хаяж 2 удаа суусан байх шаардлагатай тул эхний ээлжид Монгол Улсад Adventure Guide Training сургалтыг нэг удаа зохион байгуулах нь зүйтэй гэж үзэв. Мөн уг сургалтыг МТО-гийн хүсэлтийн дагуу өвлийн аялал жуулчлалын чиглэл рүү төвлөрүүлэн зохион байгуулах боломжтой талаар ярилцсан.</p> <p>МТО-гийн АТТА-тай хийх эхний шатны хамтын ажиллагааны төсөв ойролцоогоор 57,000 ам.доллар байхаар тооцогдсон бөгөөд үүнээс Adventure Guide Training сургалтын нэг удаагийн шууд зардал нь 36,000 ам.доллар байна. Үлдэж болох төсвөөр 2025 оны 05 дугаар сард АНУ-ын Колорадо мужид болох АТТА-гийн томоохон хурлын үеэр Монгол Улсын аялал жуулчлалыг сурталчилсан жижиг арга хэмжээ зохион байгуулах боломжийг мөн авч үзсэн.</p> <p>Шинэчилсэн мэдээллээр, 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо нь Adventure Travel Trade Association-тай хамтран "AdventureEDU" хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан. Уг хөтөлбөрийн хүрээнд АТТА-гийн мэргэшсэн сургагч багш нар 2025 оны IV улиралд Монгол Улсад хүрэлцэн ирж, адал явдалт аялал эрхлэгч байгууллагуудын төлөөлөл, аяллын хөтөч нар, орон нутгийн операторуудад зориулсан сургалт, чадавх бэхжүүлэх семинар зохион байгуулахаар болсон.</p> <p>Сургалтын зорилго нь Монголын аяллын үйлчилгээ үзүүлэгчдийг олон улсын адал явдалт аяллын хөтөчийн мэргэшлийн стандартын дагуу хөгжүүлэх, байгаль орчинд ээлтэй, хариуцлагатай аяллын зарчимд суурилсан үйлчилгээ үзүүлэх чадварыг нэмэгдүүлэхэд оршино. Сургалтын төгсгөлд оролцогчдод AdventureEDU-ийн гэрчилгээ олгож, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх боломж бүрдэнэ. Мөн сургалтын үр дүн, оролцогчдын сэтгэгдлийг тусгасан нийтлэл AdventureTravelNews цахим сэтгүүлд нийлгэгдэж, АТТА-гийн 35,000 гаруй гишүүнд хүрэх юм.</p>	0%
--------	---	-----------------------	---	--	--	---	----

2.1.16	Аялал жуулчлалын боловсрол судалгаа, олон улсын эрдэм шинжилгээний хурал	8.8 (АЖМХ-ны санхүүжилт)		АТФ 2026 олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах	<p>БЭЛТГЭЛ АЖЛЫН ХҮРЭЭНИЙ ТАЙЛАН  Арга хэмжээний нэр: Asia Tourism Forum 2026 (ATF 2026)  Хаана: Улаанбаатар хот, Монгол Улс  Хэзээ: 2026 оны 6-р сарын 11-13  Зохион байгуулагчид:  АЖМХ-НЭЗХЭ  Хонконгийн Политехникийн Их Сургууль (Hong Kong Polytechnic University – SHTM)</p> <p>1. Тойм мэдээлэл  Asia Tourism Forum нь аялал жуулчлалын салбарын бүс нутгийн хамгийн нэр хүндтэй академик болон бодлогын арга хэмжээнүүдийн нэг юм. Монгол Улсад анх удаа зохион байгуулагдах гэж буй ATF 2026 нь судалгаа, бодлого, бизнесийн гурвалсан харилцааг хөхиүлэн дэмжих зорилготой.</p> <p>2. Бэлтгэл ажлын хүрээнд хийгдсэн ажил  2.1 Зохион байгуулах түншүүдтэй хамтын ажиллагаа эхлүүлсэн  Hong Kong Polytechnic University-тэй хамтран ажиллах урьдчилсан тохиролцоог хийсэн  Зохион байгуулах үндсэн бүтэц, зохион байгуулалтын комиссын бүрэлдэхүүн боловсруулах шатандаа явж байна  2.2 Хөтөлбөрийн бүтцийг боловсруулж эхэлсэн  2.3 Вэбсайтын хөгжүүлэлт эхэлсэн  3 үндсэн чиглэлээр хөтөлбөрийн агуулгыг төлөвлөж байна:  Академик хурал (Academic Conference) – судалгааны илтгэл, шинжилгээ  Бодлогын дугуй ширээний уулзалт (Policy Forum) – сайд нарын болон бодлого боловсруулагчдын оролцоо  Фам тур  2.3 Байршил, дэд бүтцийн судалгаа  Үндсэн хурал, үзэсгэлэн, хүлээн авалтын боломжит байршлуудыг шалгаруулж байна:  – Shangri-La Hotel / Улаанбаатар зочид буудал / Chinggis Khan Museum  – Монголын соёлын төвүүд, музейн орон зай, шинээр нээгдэх газрууд  Дэд бүтцийн хангалт, техникийн шаардлагын судалгаа эхлүүлсэн  2.4 Бренд, маркетингийн чиглэлээр</p> <p>Go Mongolia үндэсний брэндийн хүрээнд сурталчилгааны стратеги, танилцуулга, видео зэрэг эхний контентууд төлөвлөгдөж байна  Олон улсын вэбсайт, сошиал платформуудаар дамжуулан сурталчлах хугацаа, механизмыг тогтоож байна</p> <p>3. Саад бэрхшээл, анхаарах асуудал  Санхүүжилтийн эх үүсвэр, дэмжлэгийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай  Олон улсын оролцогчдын урт хугацааны төлөвлөлтийг хүндэтгэн, эрт тодорхой байдал бүрдүүлэх шаардлагатай</p> <p>4. Цаашдын төлөвлөгөө (2025 оны 2-р хагас – 2026 оны 1-р улирал)  Олон улсын түншүүдтэй санамж бичиг үзэглэх  Оролцогчдын урилга, зохион байгуулах багийн баталгаажуулалт  Хөтөлбөрийн дэлгэрэнгүй агуулга, илтгэгчдийн нэрс  Вэбсайт болон бүртгэлийн систем нээх  Хэвлэл мэдээллийн түншлэл, олон улсын сурталчилгаа эхлүүлэх  Санхүүжилт, ивээн тэтгэгчдийн судалгаа, гэрээ хийх</p> <p>5. Дүгнэлт  АТФ 2026 нь Монгол Улсын аялал жуулчлалын нэр хүндийг тив, дэлхийн хэмжээнд өргөх, олон улсын судалгаа, бодлого, бизнесийн хэлэлцүүлгийг нутагтаа хүлээн авах ховор боломж бөгөөд энэхүү бэлтгэл ажлыг төлөвлөгөөтэй, шат дараатайгаар гүйцэтгэж байна.</p>	
--------	--	--------------------------	--	---	---	--

2.1.17	Мөсөн сийлбэрчдийн олон улсын уралдаан	220			<p>"Мазаалай-2025" олон улсын мөсөн сийлбэрийн тэмцээн нь Монгол Улсын Засгийн газрын бодлого, "Монголд зочлох жил"-ийн хүрээнд өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, Монгол Улсыг олон улсад сурталчлах, мазаалай баавгайг хамгаалах үйлсийг дэмжих зорилгоор 2025 оны 01 дүгээр сарын 23–26-ны өдрүүдэд Улаанбаатар хотод амжилттай зохион байгуулагдсан. Зохион байгуулалт  Санаачлагч: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам  Зохион байгуулагч: Монголын Үндэсний Мөсөн Сийлбэрийн Холбоо  Хугацаа: 2025.01.23–26  Үргэлжилсэн хугацаа: 4 хоног  Тэмцээнийг нээлт, уралдаан, бүтээл хийх үе шат, шүүлт, шагнал гардуулах, хаалтын арга хэмжээний дарааллаар зохион байгуулсан.  Тэмцээнд нийт 28 уран бүтээлч оролцож, 14 баг бүрдэн уралдсан. Монгол, АНУ, ОХУ, БНХАУ, БНСУ, БНЧУ, БНПУ, Малайз, Мексик, Якут зэрэг улс, бүс нутгийн уран бүтээлчид оролцсон. Тэмцээний хугацаанд 85 тонн мөс ашиглан 500 м² талбайд 14 бүтээл урлагдсан. Нээлтийн үйл ажиллагаа зохион байгуулагдаж, уран бүтээлчид 3 хоногийн турш бүтээлээ хийж, мэргэжлийн шүүгчдийн бүрэлдэхүүн үнэлгээ хийж, шагнал гардуулах ёслол, хаалтын ажиллагаа зохион байгуулагдсан. Оролцогчдод зочид буудал, хоол, унаа, аюулгүй ажиллагаа, дулаацах орчин, халуун ундаа, хотын аяллын үйлчилгээг бүрэн үзүүлсэн.  Арга хэмжээг зохион байгуулснаар өвлийн аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болсон, Монгол Улсыг олон улсад сурталчлах боломж нэмэгдсэн, олон улсын уран бүтээлчидтэй туршлага солилцсон, дотоодын уран бүтээлчдийг дэмжсэн, соёлын бүтээл үйлдвэрлэл болон эвент аялал жуулчлал хөгжихөд бодит хувь нэмэр оруулсан.  Шагнал урамшуулал  1-р байр – 8,000,000₮  2-р байр – 5,000,000₮  3-р байр – 3,000,000₮  4–14-р байр – 2,000,000₮</p> <p>Тэмцээнийг зохион байгуулахад нийт 220,000,000 төгрөгийн төсөв зарцуулсан. Үүнд реклам, сурталчилгаа, оролцогчдын зам, байр, хоол, талбайн бэлтгэл, тоног төхөөрөмж, мөс бэлтгэл, шагнал урамшуулал болон зохион байгуулалтын бусад зардлууд багтсан.  "Мазаалай-2025" олон улсын мөсөн сийлбэрийн тэмцээн нь төлөвлөгөөний дагуу амжилттай зохион байгуулагдаж, өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, Монгол Улсын олон улсын имижийг нэмэгдүүлэхэд үр дүнтэй арга хэмжээ болсон.</p>	100%
--------	--	-----	--	--	---	------

2.1.18	Фам тур зохион байгуулах	(80 санхүүжилт олгогдоогүй) 19 АЖМХ болон Тур операторууд санхүүжүүлсэн			Олон улсын нэр хүндтэй аялал жуулчлалын мэргэжилтэн, хувь хүмүүс, байгууллагыг урьж Монгол улсыг сурталчилсан, зах зээлийн боломжит хүрээг тэлсэн Фам тур зохион байгуулах.	<p>Фам тур 1.</p> <p>Зорилго: Францын аялал жуулчлалын мэргэжилтэн Benoit Tredez Монгол Улсад 2025 оны 8-р сард зочлон, Монголын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, бодлогыг сурталчлах, контент бүтээж франц хэлтэн зах зээлд түгээх зорилготой.</p> <p>Оролцогчид: Benoit Tredez (Trecom, Tutos Voyage) Théo Tredez</p> <p>Танилцах аялал: 2025.08.02–08.18</p> <p>Сурталчилгааны суваг: LinkedIn (21,000+ дагагч), Facebook, YouTube, TourMag.fr, WhatsApp, email campaign (20,450+ хүлээн авагч)</p> <p>Хүрэх үр дүн: Монгол руу багц аялал санал болгодог Францын операторын тоог 50 → 100 болгох Франц жуулчдын тоог 6,056 → 12,000 болгох Франц зах зээлээс ₮6 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олох боломж Монголыг "тогтвортой аялал"-ын чиглэлээр сурталчлах, Travel Life, ATES зэрэг байгууллагуудаар дамжуулан хүлээн зөвшөөрөгдөх</p> <p>Танилцуулах сувгууд: Видео (3–5 мин × 12): YouTube, Trotters TV, LinkedIn Нийтлэл: TourMag, La Quotidienne du Tourisme Мэйл, WhatsApp маркетинг: 20,450 мэргэжилтэн</p> <p>Энэхүү фам тур нь төлөвлөлтийн шатандаа явж буй бөгөөд одоогийн байдлаар маршрут, хугацааг тодорхой болгосон байна.</p> <p>Фам тур 2.</p> <p>Хугацаа: 2025 оны 8-р сарын 25–27</p> <p>Байршил: Хэнтий аймаг, Бурхан Халдун уул</p> <p>Оролцогчид: Олон улсын нэр хүндтэй эрдэмтэн судлаачид /Кэмбрижийн их сургуулийн эрдэмтэд/</p> <p>Зорилго: Монголчуудын соёл, түүхийн эх сурвалж болох Бурхан Халдун уулын газарзүйн, түүхэн, соёлын утга агуулгыг судалж, газар дээр нь мэдрүүлэх</p> <p>Аяллын хүрээнд: Дэлхийн түүхэн дэх Монголын гүйцэтгэсэн үүрэг, өв уламжлалын эх сурвалжийг газар дээр нь тайлбарлах Судлаачдын хооронд мэдлэг солилцох, Монголын өв соёлын талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх Бурхан Халдуны ЮНЕСКО-ийн дэлхийн өвийн газар болох ач холбогдлыг тодорхойлох</p> <p>Үр дүнгийн дүгнэлт: Судалгааны үнэ цэн нэмэгдэнэ Соёлын өвийн ач холбогдол нэмэгдэнэ Монголын аялал жуулчлалын брэндэд дэмжлэг болно Олон улсын хамтын ажиллагаа өргөжнө</p> <p>Энэхүү фам тур нь төлөвлөлтийн шатандаа явж буй бөгөөд одоогийн байдлаар маршрут, хугацааг тодорхой болгосон байна.</p>
--------	--------------------------	---	--	--	---	---

2.1.19	"Нүүдэлчин" Дэлхийн соёлын фестивал	төсөвгүй	Жилдээ 1 удаа зохион байгуулагдана		Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Соёл урлагийн газар, ССАЖЗЯ, АЖМХ, Монголын тогооч нарын холбоотой хамтран зохион байгуулсан	ЮНЕСКО-гийн "Соёлын биет бус өвийг хамгаалах тухай" 2003 оны КОНВЕНЦ, "Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай" 2005 оны Конвенц, соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 39 зүгээр зүйлийн 39.2 дахь заалт, монгол улсын засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 41 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестиваль дөрөв дэх жилдээ зохион байгуулагдсан. ССАЖЗЯ-ны Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Соёл, Урлагийн газар, Нийслэлийн аялал жуулчлалын газар, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо НЭЗХЭ, Монголын тогооч нарын холбоо, Монголын Мастер тогооч нарын холбоо, Монголын Ахлах тогооч нарын академи зэрэг мэргэжлийн 8 байгууллагууд хамтран ажилласан. Ажлын хэсгийн эхний уулзалт 2025 оны 07 дугаар сарын 31-ний өдөр ЗГХЭГ-н СУГ хурлын танхимд болсон ба хуралд ССАЖЗЯ-ны Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас, Н. Болормаа, М. Гантулга, Засгийн газрын ЗГХА Соёл, урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Цэнд-Аюуш, ССӨХГ-н Соёлын биет бус өвийн ахлах мэргэжилтэн Ж.Насанжаргал, Соёлын аялал жуулчлалын бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн Э.Тайшир, Нийслэлийн аялал жуулчлалын газрын Мэдээлэл сурталчилгааны хэлтсийн дарга Н. Алтанзаяа, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо НЭЗХЭ-ээс Сургалт, судалгаа хариуцсан менежер С. Нина нар хамтран 11 Угсаатны 33 нэр төрлийн хоол, Монгол үндэстний хоолны 25 нэр төрөл, Олон үндэстэний 5 нэр төрлийн хоол зэргээр нийт 44 мэргэжлийн хоол үйлдвэрлэлийн байгууллагыг хамруулган 2025 оны 08 сарын 08 сарын 22-ний өдрөөс 08 сарын 24-ний өдрүүдэд 3 өдөр тасралтгүй Налайх дүүргийн Тайж уулын бэлд зохион байгуулсан болно.	
Стратеги төлөвлөгөөний зорилго 3							
Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг бэлтгэх, мэргэжлийн удирдлагаар хангах, мэргэжлийн сургалт, эрдэм шинжилгээний чиглэлээр холбогдох иргэн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх							
3.1	Зорилт 1. Хамтарсан ажлын хэрэгжилт						
3.1.1	Жуулчны хөтөч тайлбарлагчдад зориулсан нэгдсэн сан бүрдүүлэх, үнэмлэх олгох ажлыг зохион байгуулах	(100 санхүүжилт хүлээгдэж байгаа)	Гадаад хэлний мэдлэгийн тодорхой түвшинг хангасан, түүх, соёл, газар зүйн мэдлэгтэй, аялал жуулчлалын салбарыг төлөөлж чадахуйц мэргэжлийн ур чадвартай байх	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд /хуучин нэрээр/-ын 2023 оны 12-р сарын сарын 28-ны өдрийн А/656 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Жуулчны хөтөч тайлбарлагчид үнэмлэх олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох болон мэргэжлийн ур чадварын ангилал, зэрэглэл тогтоох журам"-ын хэрэгжилт	Журмын хэрэгжилтыг мөрдсөн, жуулчдын аюлгүй байдлыг бүрэн хангасан байх	Жуулчны хөтөч тайлбарлагчид мэргэжлийн үнэмлэх олгох, сунгах, сэргээх, түдгэлзүүлэх, хүчингүй болгох болон мэргэжлийн ур чадварын ангилал, зэрэглэл тогтоох журмын хэрэгжилтийн хүрээнд 2025 оны эхний улирлын шалгалтад 46, II улиралд 22 хөтөч тэнцэж нийт 68 хөтөч үнэмлэхийн болзол хангаад үнэмлэх авсан. Хэрэгжилтийг Мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын мэргэжлийн түвшинд зохион байгуулах ажлыг хариуцан гүйцэтгэсэн.  Мэдлэгийн сан боловсруулах асуудлыг зардал багссантай холбоотой хийгдэх ажлууд нь хойшлогдож 2026 оноос хийхээр төлөвлөгдсөн байгааг яамны холбогдох мэргэжилтэн болон МХТХ-ын хариуцсан мэргэжилтэн мэдэгдсэн.	
3.1.2	Аялал жуулчлалын салбарт тулгамдаж буй асуудлыг тодорхойлох	150 олгогдоогүй	Мэргэжлийн судлаачид судалгаа хийх	Салбарын тулгамдаж буй асуудлаар	Олон улсын бага хурлын бэлтгэл ажлын хүрээнд судалгаа хийх	Төлөвлөгдсөн 4 төрлийн судалгааны ажлын зардал төрөөс олгогдохгүй болсон тул хийгдээгүй болно.	100%
3.1.3	"ГРАНД ТУР-2025" аялал жуулчлалын Улсын XXIII олимпиад	25 20 АЖМХ гишүүдийн татвараас санхүүжүүлсэн	Жилдээ 2 улиралд 6 төрлөөр зохион байгуулагдана.	Мэргэжлийн мэдлэг, ур чадвараа сорьсон тэмцээн	Аялал жуулчлал, Зочлох үйлчилгээний мэргэжлээр суралцаж буй оюутнууд	"ГРАНД ТУР-2025" аялал жуулчлалын Улсын XXIII олимпиадын #Хаврын тэмцээнүүд: Сесим Service бизнес загварчлалын цахим тэмцээн Центавр мэргэжлийн мэдлэг, ур чадварын тэмцээн Tourism Infographic content контент бүтээх тэмцээнүүд 2025 оны IY сарын 22-23-ны өдрүүдэд #Намрын тэмцээнүүд: Оюутны эрдэм шинжилгээний хурал Grand Tour Спорт аяллын тэмцээн Аялал жуулчлалыг сурталчлах үзэсгэлэн тэмцээнүүд 2025 оны IX сарын 20-27-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. Үлдэгдэл төлбөр болох 6 сая төгрөг хүлээгдэж байна.	100%

3.1.4	Нийслэлийн зочид буудал, байршуулах үйлчилгээний газруудын судалгааг хийх	20	14 хоногийн хугацаатай хийх	Нөөц, даацын судалгаа хийх	Нийслэл хотын 9 дүүргийн зочид буудал, байршуулах үйлчилгээний газрууд	"ЖУУЛЧДЫГ БАЙР СУУЦААР ХАНГАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН СУДАЛГАА ХИЙХ, НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛОХ" судалгааг 2025 оны 10 дугаар сарын 17-ний өдрөөс 10 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл 14 хоногийн хугацаатай хийсэн. Тус судалгаанд нийслэл хотын 9 дүүргийн зочид буудал, байршуулах үйлчилгээний 423 байгууллага хамрагдсан ба 9789 өрөөтэй, 18383 орны хүчин чадалтай гэж гарсан байна. Мөн тус судалгааг хийсэн зардлаа аваагүй байгаа болно.	100%
<b>Стратеги төлөвлөгөөний зорилго 4 Сургалт, судалгааны хүрээнд хийгдсэн ажлууд</b>							
<p style="text-align: center;"><i>Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн үндэслэл:</i></p> <p>Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрт 4.4.1-д "аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн эрэлтэд нийцүүлэн сургалтын хөтөлбөрийг шинэчлэх", 4.4.2-д "хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, дадлагажуулах, чадавхжуулах ажлыг зохион байгуулах", 4.4.3-д "аялал жуулчлалын салбарын хөтөч-тайлбарлаач болон зочлох үйлчилгээний сургаач багш, ажилтнуудын үр чадварыг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулж, тэдгээрийг хамруулах", Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогын 4.5.5-д "аялал жуулчлалын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааг тогтмол хийж, аялал жуулчлалын сургалт, судалгаа, үйлдвэрлэлд ашиглах боломжийг бүрдүүлэх", 4.5.6-д "ажлын байрны стандартад нийцсэн аялал жуулчлалын үйлчилгээний ажилтны сургалтын хөтөлбөрийг боловсруулж, батлуулах", 4.5.7-д "аялал жуулчлалын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв байгуулах" зэрэг тус тус заасаны дагуу Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо НЭЗХЭ нь Монгол Улсын Боловсролын сайдын 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/49 тоот тушаалд Мэргэжлийн болон техникийн боловсролын мэргэжлийн чиглэлийн индекс батлах тухай тушаалд тус тус тусасаны дагуу Аялал жуулчлалын салбарт харьяалагдах 2 мэргэжлээр дүгнэлт гаргуулахаар зорьж байна.</p> <p>Аялал жуулчлалын тухай хуулийн 91.1, 91.2, МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.4-д "Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, жуулчдын тоог нэг саяд хүргэнэ.", заасантай холбогдуулан аялал жуулчлал, зочлох үйлчилгээ эрхлэгч ирээдэд стандартыг сурталчлах ажлуудыг сургалтаар хүргэхээр тус тус ажлуудыг тусгаад байна. Мөн аялал жуулчлалын салбарын хэмжээнд зочид буудлын нээсэн дата мэдээллийг гаргаж, хүртээмжтэй ажиллахыг зорьж дараах ажлуудыг төлөвлөсөн болно.</p> <p style="text-align: center;"><b>САЛБАРЫН МЭДЭЭЛЛИЙН ОЛОН НИЙТЭД ХҮРГЭЖ, МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭСЭН БАЙДАЛ</b></p> <p>Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны сошиал хуудас болон вэбсайтад үйл ажиллагааны мэдээллийг олон нийтэд тогтмол мэдээллэж байна. Тайлант хугацаанд Аялал жуулчлалын мэргэжлийн холбооноос маркетинг, хэвлэл мэдээллийн үйл ажиллагааг төлөвлөгөөтэй, системтэй хэрэгжүүлсний үр дүнд салбарын мэдээллийн хүртээмж, нөлөөлөл дижитал орчинд мэдэгдэхүйц нэмэгдсэн байна.</p> <p>Дижитал сувгийн үндсэн үзүүлэлтүүдийг авч үзвэл пэйж хуудасны нийт үзэлт 7,000,000-д хүрч, өмнөх үетэй харьцуулахад 55.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Контентын нийт оролцоо 54,200 болж, 38.8 хувиар нэмэгдсэн нь албан мэдээ, эвентийн шуурхай сурвалжилгаа, салбарын бодит мэдээлэл хэрэглэгчдэд үр дүнтэй хүрч байгааг харуулж байна. Тайлант хугацаанд 97,900 удаагийн хуудасны зочилт бүртгэгдэж, өдөрт дунджаар 400–900 хэрэглэгч тогтмол хандсан байна.</p> <p>Дагагчдын бүтцийг авч үзвэл пэйжийн нийт дагагч 20,382-д хүрч, насны хувьд 25–44 насны хэрэглэгчид давамгайлж, хүйсийн харьцаа эмэгтэй 57 хувь, эрэгтэй 43 хувь байна. Газарзүйн хамрах хүрээ нь зөвхөн Улаанбаатар хотод төвлөрөхөөс гарч, Дархан, Эрдэнэт, Хөвсгөл, Өмнөговь, Хэнтий зэрэг аймгуудаас тогтмол хандалттай болсон бөгөөд гадаад улсаас БНСУ, Япон, АНУ, Герман, Тайланд зэрэг орнуудаас хэрэглэгчид дагаж мэдээлэл авч байна. Контентын бодлогын хүрээнд сард дунджаар 100–150 албан мэдээ, мэдээлэл бэлтгэн нийтэлж, долоо хоног бүр тайлан гаргах тогтолцоог нэвтрүүлсэн. Үүний үр дүнд контентын найруулга, бүтэц стандартчлагдаж, салбарын албан мэдээллийг нэг мөр ойлгомжтой хүргэх нөхцөл бүрдсэн.</p> <p>Орон нутгийн мэдээллийн хүрээнд улсын 21 аймгийг хамарсан өдөр тутмын мэдээллийн сүлжээ бүрдүүлж, аймгаас ирэх мэдээллийг нэг төвөөс цаг алдалгүй түгээдэг тогтолцоонд шилжсэн нь салбарын мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг улсын хэмжээнд нэмэгдүүлсэн бодит үр дүн болж байна.</p> <p>Тайлант хугацаанд зохион байгуулагдсан үндэсний болон олон улсын томоохон арга хэмжээнүүдийн хүрээнд медиа, контентын ажлыг гүйцэтгэж, давхардсан тоогоор 200 гаруй контент (мэдээ, фото, видео, сурвалжилга) олон нийтэд түгээгдсэн. Үүнд олон улсын үзэсгэлэн, наадам, салбарын зөвлөгөөн, хурал, уулзалтууд багтаж, эдгээр арга хэмжээнүүдийн талаарх мэдээллийг шуурхай, бодитойгоор хүргэх боломж бүрдсэн.</p> <p>Дээрх үр дүнгээс дүгнэхэд маркетинг, хэвлэл мэдээллийн үйл ажиллагааг системтэй хэрэгжүүлснээр Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо нь салбарын албан мэдээллийн үндсэн дижитал суваг болон төлөвшиж, цаашид аялал жуулчлалын бодлого, хөтөлбөр, арга хэмжээний мэдээллийг олон нийтэд илүү үр нөлөөтэй хүргэх бодит суурь бүрдсэн гэж үзэж байна.</p>							
4.1	Зорилт 1. "Хоёр мэргэжлийн чиглэлийн сургалтын хөтөлбөр боловсруулж, дүгнэлт гаргуулах"						
4.1.1	101301 Зочид буудал, зоогийн газрын үйлчилгээ	Гишүүдийн татвараар санхүүжүүлэв	4 хөтөлбөр боловсруулж, дүгнэлт гаргуулсан	144 цагийн, богино хугацааны, чадамжийн гэрчилгээ олгох сургалт	Аялал жуулчлалын салбарт ажиллах хүсэлтэй мэргэжлийн бус иргэдэд	Зочид буудлын зочин хүлээн авагч, Өрөөний үйлчлэгч, Рестораны зөөгч, Тогооч мэргэжлүүдээр 4 хөтөлбөр боловсруулж, дүгнэлт гаргуулан, сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөө албан ёсоор авсан.	100%
4.1.2	101501 Аялал жуулчлалын үйлчилгээ	Гишүүдийн татвараар санхүүжүүлэв	1 хөтөлбөр боловсруулж, дүгнэлт гаргуулсан			Жуулчны хөтөч тайлбарлагч мэргэжлийн сургалтын хөтөлбөр боловсруулж, дүгнэлт гаргуулан, сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөө албан ёсоор авсан.	100%
4.1.3	Суурь үр чадварын сургалт явуулах эрх аван сургагч багшаар сургалт судалгаа хариуцсан менежер С. Нина - г бэлтгэсэн	Гишүүдийн татвараар санхүүжүүлэв	Богино хугацааны сургалт			Зорилтот бүлгийн иргэдэд "Суурь үр чадвар"-ын сургалт явуулж салбарын хүний нөөцийг хангах ажилыг эхлүүлэхээр 9 дүүрэгтэй хамтран ажиллах хүсэлт илгээсэн. Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газарт хүсэлтээ илгээсэн.	100%

4.1.4	Дорноговь аймагт сургалт зохион байгуулах	600,000 гишүүдийн татвараар санхүүжүүлэв.			Дорноговь аймгийн аялал жуулчлал, зочлох үйлчилгээний бизнес эрхлэгчид	Зочлох үйлчилгээний стандартыг мөрдөж ажиллах тухай сургалт, зөвлөгөөнийг 2025 оны 03 сарын 23-25-ний өдрүүдэд Дорноговь аймгийн ЗДТГазар, <a href="#">Дорноговь аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар</a> , <a href="#">Дорноговь Аймгийн Аялал Жуулчлалын Холбоо</a> ажилласан ба Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны зүгээс зохион байгуулалт дээр дэмжин ажиллаж байна. Энэхүү нэгдсэн сургалт, зөвлөгөөн нь төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах, аялал жуулчлалын ач холбогдлыг таниулах, зочлох үйлчилгээний байгууллагын удирдах болон үйлчилгээний ажилтнуудад үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээ, үйлчилгээний байгууллагаас хүсэж буй үнэ цэн, үйлчилгээний стандарт, ажилтны харилцаа, хандлага зэрэг агуулгын хүрээнд ур чадвар, арга зүйн чадамж олгох зорилгоор АЖМХ-ны Дэд ерөнхийлөгч, ХЭЗЧҮХ-ны дарга Э. Тэнгисболд, Олон нийттэй харилцах албаны менежер М. Дархижав, Сургалт хариуцсан менежер С. Нина нар 2025 оны 03 дугаар сарын 23-ний өдрөөс 03 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл сургалт хийсэн юм. Тус сургалтаар Аялал жуулчлалын салбарын чиг хандлага, хууль эрх зүй, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын талаар удирдах болон үйлчилгээний ажилтнуудад арга зүйн сургалт, зөвлөгөөг амжилттай өгч ажиллаа.	100%
4.1.5	Дорнод аймагт зочлох үйлчилгээний сургалт зохион байгуулах	1,425,000	2 өдрийн арга хэмжээ			Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамтай хамтран “Аялал жуулчлал-хамтын хөгжил” сэдэвт сургалт, хэлэлцүүлгийг 2025 оны 11 дүгээр сарын 23, 24-ний өдрүүдэд Чойбалсан хотод зохион байгуулсан. Сургалт, зөвлөгөөний хүрээнд “Жуулчин тээврийн үйлчилгээ” сэдвээр жуулчин тээврийн үйлчилгээ үзүүлдэг 66 иргэн, аж ахуйн нэгж, “Зочид буудлын зочин хүлээн авагч болон өрөөний цэвэрлэгээний технологийн мэдлэг олгох” сэдвээр 15 иргэн, “Аяллын хөтөч тайлбарлагч”-ийн сэдвээр тухайн үйлчилгээг үзүүлэх сонирхолтой 84 иргэн, гадаад улсаас олон улсын аялагчид хүлээж авахыг зорин ажиллаж буй тур агент, тур оператороор ажиллах сонирхолтой МУИС-ын харъяа Зүүн бүсийн сургуулийн Мэдээллийн технологи, Бизнесийн удирлага, Хятад хэлний ангийн 31 оюутан, “Онлайн захиалга, онлайн төлбөр тооцооны систем, хайлтын системт олон улсын аялал жуулчлалын цахим платформуудад бизнесүүдийн борлуулалтыг автоматжуулан ажиллаж, орлогоо нэмэгдүүлэх буюу аялал жуулчлалын дижитал маркетер гэх ажлын байрны тухай ойлголтыг олгох” практик сургалтад 60 иргэн тус тус хамрагдаж, аялал жуулчлалын үйлчилгээний чиглэлээр мэдлэг, дадал, чадвар олж авсан.	100%
4.1.6	Start Up сургалт	АЖМХ	1 өдрийн сургалт		Аялал жуулчлалын салбарт шинээр бизнес эрхлэгч нарт	Аялал жуулчлалын мэргэжлийн холбооноос гишүүддээ болон салбарт шинээр тур операторын бизнес эрхлэгч нарт зориулсан анхан шатны сургалтыг явууллаа. Сургалтад 13 байгууллага бүртгүүлснээс 10 байгууллагын захирал, менежерүүд суусан. Сургалтыг 7 агуулгын хүрээнд зохион байгуулсан. Сургалтад Аялал жуулчлалын салбарт туршлагатай тур операторуудын захиралууд орж сургалт, зөвлөгөө өгч ажилласан. Оролцогчид сэтгэл өндөр, асуух зүйл их байсан тул багш нар цагтаа багтаж хичээлээ заахад хүндрэл учирч цаг хэтрүүлэн, товлосон цагаасаа хэтрүүлж гарч ирж байсан. Сургалтыг АЖМХ-ны Удирдах зөвлөлийн дараах гишүүд сургалт орсон болно. Үүнд: 1. Үнэ санал боловсруулах ба зардлын тооцоо Үнийн бүтэц, ашгийн тооцоо - Валютын ханш, улирлын үнийн стратеги, Тур багцын үнэ санал гаргах аргачлал /АЖМХ-ны УЗ гишүүн, Дисковер Монголиа ХХК-н захирал Б. Барсболд/ 2. Зах зээлийн судалгаа ба бүтээгдэхүүн хөгжүүлэлт- Байгаль, соёл, адал явдал, тусгай аяллын төрлүүд, Зорилтот зах зээл, хэрэглэгчийн зан төлөв, Бүтээгдэхүүн, маршрут, хөтөлбөр боловсруулах /АЖМХ-ын УЗ гишүүн, Join Me платформын захирал Э. Цоморлиг/ 3. Олон улсын хамтын ажиллагаа ба түншлэл -B2B сүлжээ, Travel fair, MOU, Гадаад зах зээлд гарах стратеги, Аялал жуулчлалын байгууллагуудтай холбогдох н. Лхам-Эрдэнэ/ 4. Монголын аялал жуулчлалын чиг хандлага - Монголын аялал жуулчлалын чиг хандлага, Тур операторын үүрэг, Зах зээлийн орчин /АЖМХ-ны гүйцэтгэх захирал М. Нарангэрэл/ Ажлын албаны Хууль Хууль эрх зүйн орчин -Тур операторын бизнес эрхлэх журам, Лиценз, татвар, даатгал, гэрээний эрх зүй /АЖМХ-ны хуульч Р. Лхагвабаяр/  Маркетинг ба борлуулалт Дижитал маркетинг - Борлуулалтын сувгууд, хамтын ажиллагаа /Аялал жуулчлалын технологийн төвийн захирал Г. Анхбаяр/  Харилцагчийн үйлчилгээ ба аяллын менежмент - Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, Аяллын явцын зохион байгуулалт, Гомдол, сөрөг сэтгэгдэлтэй ажиллах зэрэг сэдвээр нэг өдрийн сургалт орсон болно.	100%
4.2	Зорилт 2. Бүсчилсэн хөгжлийн хүрээнд хийгдэх ажлууд						

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны 03 дугаар тэмдэглэл, 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны 05 дугаар тэмдэглэл, Бүсчилсэн хөгжлийн Үндэсний хорооны 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 01 дүгээр тогтоол, мөн Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны шийдвэрийн хүрээнд бус бүрд Бүсийн зөвлөлийн хуралдааныг зохион байгуулж, бүсүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, бус тус бүрд шаардлагатай мега төслүүдийг танилцуулан хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

Хангайн бүс

Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд Хангайн бүсийн тэргүүлэх чиглэл нь төрөлжсөн аялал жуулчлал бөгөөд соёлын, түүхэн, адал явдалт, байгалийн, амралт, рашаан сувиллын чиглэлээр хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Энэ хүрээнд Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо, Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймгийн ЗДТГ, аймгийн БОАЖГ болон "АРА" комплексн төлөөлөл хамтран хэлэлцүүлэг зохион байгуулсан. Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбооны бүсчилсэн хөгжлийн ажлын хэсгийг 12 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, Хангайн бүсийн анхдугаар зөвлөгөөнд дэд бүтэц хариуцсан дэд ерөнхийлөгч О. Мөнхнасан, хууль эрх зүй хариуцсан дэд ерөнхийлөгч Э. Тэнгисболд, Удирдах зөвлөлийн гишүүн Ижилмөрөн, сургалт хариуцсан менежер С. Нина нар 04 дүгээр сарын 13-15-ны өдрүүдэд Архангай аймагт ажилласан.

Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо Хангайн бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдаанд дараах чиглэлээр оролцсон. Үүнд, үзэсгэлэнд мэргэжлийн холбоод болон байгууллагуудыг танилцуулж, аймгуудын Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын илтгэлүүдийг тавиулсан. Мөн АЖМХ-ны дэд ерөнхийлөгч О. Мөнхнасан "Бүсийн хөрөнгө оруулалт, хөгжлийн төсөл хөтөлбөрүүд" сэдэвт хэлэлцүүлэгт панелистаар оролцож, "Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, чиг хандлага" сэдвээр үндсэн илтгэл танилцуулсан.

Хуралдааны хүрээнд Архангай аймгийн Засаг дарга Б. Цэрэннадмид, Өвөрхангай аймгийн Засаг дарга О. Пүрэвдорж, Баянхонгор аймгийн Засаг дарга Д. Мөнхсайхан нартай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан.

Үзэсгэлэнгийн үеэр Архангай аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, аялал жуулчлалын асуудал хариуцсан мэргэжилтэн Г. Батцэцэг, мөн "Эртний нүүдэлчдийн өлгий нутаг" салбар холбоотой хамтран ажиллаж, салбар холбооны танилцуулгаас гадна аймагт хэрэгжиж буй "Малчин кемп" төслийг танилцуулсан. Үүнд ногоон бүрээстэй гэр, эко 00, эко түлш зэрэг бүтээгдэхүүн, шийдлүүдийг танилцуулсан.

Өвөрхангай аймгаас аялал жуулчлалын асуудал хариуцсан мэргэжилтэн М. Мөнхсүрэн, аймгийн аялал жуулчлалын холбооны УЗ-ийн гишүүн О. Ангарагсүрэн, Их Хорум зочид буудлын менежер Б. Бямбадорж нар бизнес эрхлэгчдээ төлөөлөн илтгэл тавьж, Дөрвөн бэрх жуулчны бааз, Их Хорум, Хан Хужирт, Торгоны замын нууц зэрэг нийт 4 бааз, амралтын газар оролцсон.

Баянхонгор аймгаас аялал жуулчлалын асуудал хариуцсан мэргэжилтэн Д. Сугармаа, аялал жуулчлалын холбооны зөвлөх С. Баярмагнай нар оролцож, аймаг орон нутгийн аялал жуулчлалын онцлогийг танилцуулан илтгэл тавьж, Мэргэн өргөөт амралтын газар хувийн хэвшлийг төлөөлөн оролцсон.

Мөн орон нутгийн аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарын хамтын ажиллагаа, түншлэлийг бэхжүүлэх, орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг таниулах, шилдэг хоршоодыг алдаршуулах, орон нутгийн туршлага, санаачилгыг хуваалцах, бизнес, төрийн байгууллага, төрийн бус байгууллагуудын уялдааг сайжруулах зорилготой үзэсгэлэн, танилцуулга зохион байгуулагдсан.

Хангайн бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдаан Архангай аймагт амжилттай зохион байгуулагдаж, УИХ, Засгийн газрын гишүүд, Өвөрхангай, Баянхонгор, Архангай аймаг, сум, багийн удирдлагууд, хувийн хэвшил, олон улсын болон орон нутгийн төр захиргааны байгууллага, эрдэмтэн судлаачид, иргэдийн төлөөлөл оролцсон. Хуралдаанаар Хангайн бүсийг уламжлалт мал аж ахуйн төрөлжсөн, хот байгуулалтын дэд бүсээс гадна аялал жуулчлалын чиглэлээр хөгжүүлэхээр шийдвэрлэсэн.

Хойд бүс

"Монгол Улсын үзэл баримтлал батлах тухай" тогтоолын хүрээнд хийгдэж буй Хойд бүсийн нээлтийн арга хэмжээ 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Булган аймагт болсон. Хойд бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдаан Булган, Орхон, Хөвсгөл аймгуудыг хамруулан Булган аймгийн Спортын төвд өглөөний 09:00 цагт нэгдсэн хуралдаанаар эхэлж, дараа нь панел хэлэлцүүлэг үргэлжилсэн.

Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбооны гүйцэтгэх захирал М. Нарангэрэл "Бүсийн онцлог, харьцуулалт"

Аймгуудын Засаг Дарга, Аймгийн Засаг дарга

Почивят Увссын

(150 ССАЖБ)

Бүсчилсэн

						<p>I овийн бүсийг ҮНХАУ болон Өмнөд Азийн орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлэх, уул уурхай, говийн унаган байгаль, түүх, соёлын өв, палеонтологийн нөөцөд түшиглэн аж үйлдвэрийн төрөлжсөн бүс бөгөөд ногоон эрчим хүчний дэд бүс болгон хөгжүүлэхээр төлөвлөсөн.</p> <p>Монгол Улсыг Хангайн, Баруун, Хойд, Төвийн, Зүүн, Говийн, Улаанбаатарын гэсэн долоон эдийн засгийн бүс болгон хөгжүүлэх бодлого батлагдсан бөгөөд үүний хүрээнд төлөвлөлт, хэрэгжилт, бүс нутгийн хөгжлийг дэмжих механизм, эрх зүйн орчин бүрдэж, бүс орон нутгийн хөгжлийн түвшний ялгаа багасч, эдийн засгийн өсөлт нэмэгдэх нөхцөл бүрдэж байна.</p> <p>Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 35 дугаар тушаалаар бүс нутгийн хөгжлийг дэмжих төрийн бодлогыг хэрэгжүүлэх, бүсийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн асуудлыг зохицуулах чиг үүрэг бүхий "Бүсийн зөвлөл"-ийг бүс бүрд байгуулсан. Үүнд Хангайн бүсийн зөвлөлийн даргаар Архангай аймгийн Засаг дарга, Баруун бүсийн зөвлөлийн даргаар Баян-Өлгий аймгийн Засаг дарга, Хойд бүсийн зөвлөлийн даргаар Булган аймгийн Засаг дарга, Төвийн бүсийн зөвлөлийн даргаар Дархан-Уул аймгийн Засаг дарга, Зүүн бүсийн зөвлөлийн даргаар Дорнод аймгийн Засаг дарга, Говийн бүсийн зөвлөлийн даргаар Дорноговь аймгийн Засаг даргыг тус тус томилсон.</p> <p>Намраас Төвийн бүсэд бүсчилсэн хөгжлийн хамтын ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөж байна.</p>	
4.2.2	Байршуулах хэрэгсэлийн стандартын сургалт	4,173,000 гишүүдийн татвараар санхүүжүүлэв.	Санамж бичгийн хүрээнд сургалт хийх	Дотоод, гадаадын зочид хүлээн авч буй байршуулах хэрэгсэлүүдэд зориулсан	Зочид буудал, жуулчны бааз, дэн буудал, гэр буудлын үйл ажиллагаа эрхлэгчид	<p>Баянхонгор аймагт зочлох 2025 оны 04 дүгээр сарын 14-ны өдөр "Хангайн бүсийн зөвлөл" дээр санамж бичиг байгуулсан билээ. Энэхүү санамж бичигт заасан эхний ажлаа аймгийн засаг даргын тамгын газар, <a href="#">Баянхонгор аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар</a>тай Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо хамтран "Аялал жуулчлалын бизнес эрхлэгчдийн нэгдсэн сургалт, зөвлөгөөн"-д сургалт, зөвлөгөөнд 25 бизнес эрхлэгчид оролцсон сургалт, зөвлөгөө зохион байгуулсан.</p> <p>Орхон аймагт 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр "Хойд бүсийн зөвлөл" дээр санамж бичиг байгуулсан билээ. Энэхүү санамж бичигт заасан эхний ажлаа Орхон аймгийн засаг даргын тамгын газар, <a href="#">Орхон аймгийн соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар</a>тай Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо хамтран "Зочлох үйлчилгээний сургалт", мөн Булган аймагт "Жуулчны хөтөч тайлбарлагч"-ын сургалтуудыг тус тус хийхээр төлөвлөсөн.</p>	100%
4.2.3	Зочлох үйлчилгээний практик сургалт	2,100,000 Гишүүдийн татвараар санхүүжүүлэв	Санамж бичгийн хүрээнд хийх сургалт		Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэх сонирхолтой болон эрхэлж буй иргэдэд	<p>Дундговь аймагт 2025 оны 05 сарын 12-ны өдөр "Говийн бүсийн зөвлөл" санамж бичиг байгуулсан билээ. Энэхүү санамж бичигт заасан эхний ажлаа аймгийн засаг даргын тамгын газар, <a href="#">Дундговь аймгийн нийгмийн бодлогын газрын соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар</a>тай хамтран нутгийн иргэдийг түшиглэсэн аялал жуулчлалын 92 бизнес эрхлэгчдэд сургалт хийсэн.</p>	100%
4.2.4	Гишүүдэд зориулсан сургалт	Оролцогчдын төлбөр	Үйл ажиллагаа эрхлэхэд мэргэжлийн мэдлэг, ур чадварын шаардлага	Улирлын чанартай хийж гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай мэдлэг, ур чадвар, баримт бичгүүд	Бизнес эрхлэгчид	<p>2025 онд зохион байгуулсан сургалтын мэдээлэл:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Tourism Week сургалт – 333</li> <li>2. МБШТ Гандан тэгчэнлэн хийдийн сургалт – 15</li> <li>3. Баристагийн сургалт – 32</li> <li>4. Кибер аюулгүй байдлын сургалт – 46</li> <li>5. Дорноговь аймгийн зочлох үйлчилгээний сургалт – 20 байгууллага</li> <li>6. Жуулчин тээврийн сургалт – 644</li> <li>7. АТГ, ХАБЭА-ын сургалт – 15</li> <li>8. УЗ-ийн сургалт – 25</li> <li>9. Дундговь аймагт зохион байгуулсан сургалт – 92</li> <li>10. Баянхонгор аймагт зохион байгуулсан сургалт – 30</li> </ol> <p>Нийт <b>1,160</b> хүнийг сургалтад хамруулсан байна.</p>	100%

4.2.5	Сургалтын төвийн нээлтэд хамтран ажилласан	2,500,000 Гишүүдийн татвараар санхүүжүүлэв	Зочид буудал, Жуулчны бааз, Ресторен, Жуулчин тээврийн жолооч, Жуулчны хөтөч тайлбарлагч мэргэжлүүд	Нэг өдрийн мэргэшлийн сургалтыг ур чадварт суурилан зохион байгуулсан	Мэргэжлийн сургалтын байгууллагуудтай хамтран ажилласан	<p>2025 оны 05 сарын 29-ны өдөр ССАЖЗЯ-ны харьяа БНСУ-ын буцалтгүй тусламжаар барьсан сургалтын төвийн нээлтэд АЖМХ сургалтын үйл ажиллагаагаараа дэмжин оролцсон. Сургалтын үйл ажиллагааг АЖМХ-ны салбар холбоод зохион байгуулан идвэхи зүтгэл гарган оролцсон билээ.</p> <p>Мөн Торгоны зам ханган нийлүүлэгч байгууллага Жуулчны бааз, байршуулах хэрэгсэлийн салбар холбоо, Хорека институттэй хамтран ажиллаж багаж хэрэгсэл, хэрэглэгдэхүүнээр дадлагын газруудыг тоноглож ажиллахаас гадна Жуулчид тээврийн салбар холбоо Жуулчин тээвэрт явдаг 4 төрлийн авто машины аюулгүй байдлыг танилцуулж, жуулчин тээвэр эрхлэх наалтыг танилцуулсан.</p> <p>Жуулчны баазын үйлчилгээний технологи сургалтыг "Жуулчны баазын үйлчилгээний технологи" сэдвийн хүрээнд ЖББХСХ-ны тэргүүн С. Алтантуяа хариуцан ИЗИС-ын болон СЭЗИС-ын оюутнуудтай хамтран зохион байгуулсан.</p> <p>Зочид буудлын өрөөний үйлчлэгч, Зочин хүлээн авагч, рестораны сургалтуудыг Хорека институт зохион байгуулсан. Сургагч багш Д. Болорцэцэг "Зочид буудлын өрөө үйлчилгээний технологи" сэдвээр, "Зоогийн газрын өдөр тутмын үйлчилгээний технологи" Хорека институтийн сургагч багш Н.Баттулга, И.Гансүх нар зоогийн газрын сургалтыг зохион байгуулсан.</p> <p>Жуулчны хөтөч тайлбарлагчийн сургалтыг Мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбооны гүйцэтгэх захирал Б. Амаржаргал хариуцан ХААИС, Хангай ДС -ын 15 оюутантай "Жуулчны хөтөч тайлбарлагчид ур чадвар олгох сургалт"-н хүрээнд хийсэн.</p> <p>Жуулчин тээврийн сургалтыг МЖТХ-ны тэргүүн Б. Ижилмөрөн, Тээврийн цагдаагийн албаны мэргэжилтэн нар "Зорчигч тээвэр ба техникийн бүрэн бүтэн байдал, хувь хүний соёл, хууль эрх зүйн мэдээлэл, авто аяллын онцлог" сэдвүүдийн хүрээнд 245 жолоочид хийсэн ба сургалтын тахимын багтаамжаас хамааран 3 хувааж хийсэн болно.</p>	
4.2.6	КОЙКА ОУ-ын хамтын ажиллагаа	17,342,612	1-р ээлж		3 сарын хугацаатай ажиллах сайн дурын баг	<p>2025 оны 12 дугаар сарын 08-ны өдөр КОЙКА Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын 13 сайн дурын ажилтан сургалтын төвд ажиллахаар хүрэлцэн ирсэн.</p> <p>Сургалтын төвийн цахилгааны асуудлаас шалтгаалан 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбооны төв оффист төслийн менежер, орчуулагчийн хамт нийт 15 хүнийг ажлын байраар ханган ажиллуулж эхэлсэн.</p> <p>Сайн дурын ажилтнууд дараах 3 багт хуваагдан ажилласан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Сургалтын баг</li> <li>2. Гарын авлагын баг</li> <li>3. Сурталчилгааны баг</li> </ol> <p>Нэгдүгээр ээлжийн сайн дурын ажилтнуудын ажлын зорилго нь эхний шатанд өөрсдийн чиглэл тус бүрээр судалгаа хийж, 3 сарын хугацаанд ажлаа гүйцэтгэхэд чиглэсэн.</p> <p>2025 оны 12 дугаар сарын байдлаар судалгааны асуулгыг боловсруулж, судалгаа авах байгууллагуудаар ажиллах төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлсэн. Мөн ажиллах хугацаандаа сургалтын төвд 25 нэр төрлийн сургалтын хэрэглэгдэхүүн авч өгсөн байна.</p>	
4.3	Зорилт 3. Хамтарсан ажлын төслүүд						

4.3.1	Зочид буудлуудын нэгдсэн тоо баримттай болох судалгаа	20	Нийслэл хот, түүний дагуул хотуудыг хамарсан	Нэгдсэн сан бүрдүүлэх	Зочид буудал, жуулчны бааз, дэн буудал, гэр буудал, гэйст хаус	Нийслэлийн засаг даргын тамгын газар, нийслэлийн аялал жуулчлалын газар, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоотой хамтран стандартын үзлэг, шалгалт хийнгээ нөөц, даацын судалгаа хийж, сургалтын эрэлт хэрэгцээг тодорхойлон, төрөлжүүлж, үйлчилгээний чанарыг сайжруулах сургалт, зөвлөгөө хийхээр төлөвлөөд 2025 оны 06 сарын 16-ны өдрөөс ажлаа эхлүүлэхээр болсон. Мөн энэхүү ажилтай уялдуулан Цөлжилттэй тэмцэх Олон Улсын хурлын зохион байгуулалттай холбоотой Улаанбаатар хотын шаардлага хангасан 48 зочид буудлуудаар СОР-17 ажлын хэсгийн эрсдлийн үнэлгээний багтай хамтран зохион байгуулахаар болоод байна. СОР-17 ажил нь ССАЖЗЯ-ны дэд ажлын хэсгийн хүрээнд зочид буудлуудын стандарт шаардлага бүхий хуучин стандартыг мөрдөн ажиллах юм. Мөн одны зэрэглэлтэй зочид буудлуудыг аттестачлах зэргээр тус ажил явагдах юм. 2025 оны 10 сарын 17-ний өдрөөс 10 сарын 30-ний өдрийг хүртэл Нийслэл хотын 9 дүүрэгт зочид буудал, байршуулах үйлчилгээний газруудад хийсэн. Судалгаанд 423 зочид буудал, байршуулах үйлчилгээний газруудаар явж судалгааг 2 долоо хоногийн хугацаанд хийсэн болно. Судалгааны тайланг ССАЖЗЯ-ны АЖБХЗ газрын мэргэжилтэн М. Мөнхбилгүүнд 11 сарын 6-ны өдөр хүлээлгэн өгсөн болно. Санхүүжилт орж ирээгүй.	100%
4.3.2	Сургалтын төвийн хамтын ажиллагаа /КОЙКА/		КОЙКА ОУ-ын хамтын ажиллагааны байгууллага	Сургалтын төвийн менежментийн үйл ажиллагааг дэмжих	Аялал жуулчлал, Зочлох үйлчилгээний	2025 оны 09 сард КОЙКА ОУ-ын байгууллагын төлөөлөгч нартай ССАЖЗЯ-ны сайдын зөвлөх Б. Золбадрал, АЖБХЗГ-ын дарга В. Батчимэг, АЖМХ-ны гүйцэтгэх захирал М. Нарангэрэл, Сургалт, судалгааны менежер С. Нина нар уулзсан. Уулзалтаар сургалтын төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээр 11 сарын сүүлээр ирэх КОЙКА-ын сайн дурын ажилтнуудын ажиллах ажлын бэлтгэл ажил, ажлын төлөвлөгөөг ярилцаж шийдэх талаар ярилсан. Мөн 10 сард хамтран ажиллах КОЙКА-ын сайн дурын ажилтнуудыг хариуцах төслийн менежер Жу Жехег ирж уулзан хамтран ажиллах төлөвлөгөөгөө боловсруулах ажлыг эхлүүлсэн. Тус уулзалтад АЖМХ-ны гүйцэтгэх захирал М. Нарангэрэл, Сургалт, судалгаа хариуцсан менежер С. Нина, МОКТА салбар холбооны тэргүүн Наранхүү, УЗ гишүүн Олгэрэл нартай уулзаж 1-р ээлжийн багтай ямар ажил дээр төвлөрөн ажиллах талаар ярилцаж, урьдчилсан төлөвлөгөөг гаргасан. 2025 оны 12 сарын 08-ны өдрөөс БНСУ-ын КОЙКА ОУ-ын байгууллагын сайн дурын ажилтнууд сургалтын төв дээр ажиллахаар ирсэн ба АЖМХ-ны гүйцэтгэх захирал М. Нарангэрэл, Сургалт судалгаа хариуцсан менежер С. Нина, Зөвлөх Д. Бадрал, Маркетингийн менежер Ц. Үүрцайх нар хүлээн авч уулзсан. Уулзалтаар хамтран ажиллах ажлын төлөвлөгөөг танилцуулан, ажлын байр, орчин нөхцлийг танилцуулсан болно. Сайн дурын ажилтнууд сургалтын төвийн бэлэн бус байдлаас үүдэн 12 сарын 09-ний өдрөөс АЖМХ-ны төв оффис дээр 3 чиглэлээр 15 сайн дурын ажилтан ажиллахаар болсон ба АЖМХ-ны ажлын алба ажлын байрыг өөрийн байрандаа засаж тохижуулсан болно. Ингээд сургалтын хөтөлбөрийн баг, сургалтын гарын авлагын баг, сургалтын төвийг сурталчлах сурталчилгааны баг гэсэн 3 хэсгээс бүрдсэн баг тус тусынхаа ажилд орсон болно. Сургалтын хөтөлбөрийн баг сургалтын хөтөлбөрт арга зүйн дэмжлэг үзүүлэхээс гадна 2 төрлийн сургалт зохион байгуулах төлөвлөгөөг гарган бэлтгэл ажлуудыг эхлүүлсэн ба зарыг 2025 оны 12 сарын 25 -ний өдөр зарласан.	100%
4.3.3	Хүний нөөцийг дэмжих төсөл	30 сая төгрөгийг АЖМХ-ны гишүүдийн татвараас гаргасан.	Тэтгэлэгт дадлагын хүрээнд	Хүний нөөцийн тогтвортой үйл ажиллагааг хангах	Аялал жуулчлалын мэргэжлээр суралцаж буй оюутнууд	Аялал жуулчлалын сабларын хүний нөөцийг дэмжих зорилгоор 1 тэрбум тэтгэлэгт дадлагад амжилттай хамрагдсан 20 оюутанд тэтгэлэг олгох асуудлыг АМЖХ-ны УЗ-ын шийдвэрээр олгохоор болсон байна. Тус шийдвэрээр 30 оюутнуудыг тус бүр 1,5 сая төгрөг, нийт 30 сая төгрөг олгохоор шийдвэрлэсэнээс 20 сая төгрөг олгов. АЖМХ ны гишүүн байгууллагуудын төлсөн татвараас 5 хувийг суутган олгодог.	
5.1	Зорилт.5 Сургалт, судалгааны чиг үүрэгтэй холбоотой уулзалтууд						
5.1.1	ССАЖЗЯ-ны чиг үүргийн гэрээний дагуу ажлын төлөвлөгөөний уулзалт		Сургалт, судалгаатай холбоотой ажлын төлөвлөгөө	Төлөвлөгөөг хэлэлцэх	ССЧҮХ-ны гишүүд	Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны СУРГАЛТ, СУДАЛГААНЫ ЧИГ ҮҮРГИЙН ХОРОО өнгөрсөн он буюу 2024 оны ажлын дүгнэлт, 2025 оны ажлын төлөвлөгөөгөө хэлэлцэн батлав.. 2 зорилгын хүрээнд нийт 7 ажил төлөвлөв.	

5.1.2	Глобал Сивик Шэйринг ОУБ-ын уулзалт		Хамтын ажиллагааны талаар	Сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх	Сургалт, судалгааны менежерүүд	<p>БНСУ-ын ODA (Official Development Assistance) төслийг хэрэгжүүлэх тухай уулзалт зохион байгуулагдав.</p> <p>Уулзалтын хүрээнд Монгол Улсын аялал жуулчлалын салбарт хүний нөөцийг чадваржуулах, аялал жуулчлалын орчныг сайжруулах, тогтвортой хөгжлийг дэмжих чиглэлээр БНСУ-ын ODA төслийг хэрэгжүүлэх боломжийн талаар оролцогч талууд санал солилцож, хэрэгцээ шаардлагын мэдээлэл цуглуулан, төсөлд тусгах асуудлыг хэлэлцэв.</p> <p>Солонгосын талаас уулзалтад дараах төлөөлөгчид оролцов. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Глобал Сивик Шэйринг ОУБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Жу Хён Жү</li> <li>2. Глобал Сивик Шэйринг ОУБ-ын Монгол дахь салбарын захирал Н. Батдорж</li> <li>3. Global Hospitality Institute-ийн захирал Пак Гён Сүк</li> <li>4. Аялал жуулчлалын англи хэлний профессор Квон Хён Гён</li> </ol> <p>Эдгээр төлөөлөгчидтэй хамтын ажиллагааны уулзалт хийсэн болно.</p>	
5.1.3	Гадаад харилцааны яамны Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газартай хамтран ажиллах		Хамтын ажиллагааны талаар	Санамж бичигт гарын үсэг зурж хамтын ажиллагааг эхлүүлсэн	Дипломат үйлчилгээний газрын дарга, АЖМХ-ны ерөнхийлөгч	<p>Соёлын өвийг сурталчлан таниулах зорилгоор аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэх ажлын хүрээнд Аялал жуулчлалын мэргэжлийн холбоотой харилцан ойлголцлын санамж бичиг байгууллаа.</p> <p>Санамж бичгийг Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газрын захирал Б.Халиун, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо НЭЗХЭ -ийн Ерөнхийлөгч Т.Баттулга нар гарын үсэг зурж баталгаажууллаа.</p> <p>Хамран ажиллах санамж бичгийн хүрээнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Монгол Улсын Соёлын биет өв болсон Чин Ван Ханддоржийн өргөөг жуулчид, зочид төлөөлөгчдөд сурталчлан таниулах;</li> <li>2. "Монгол гэрийн онцлог, өв соёлыг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Соёлын тусгай арга хэмжээ, хөтөлбөр"-ийг хамтран хэрэгжүүлэх;</li> <li>3. Нүүдэлчдийн ахуй соёл, ёс заншлыг таниулах зорилгоор Чин Ван Ханддоржийн өргөөнд Монгол үндэсний зоог гүнцэгээр жуулчид, зочид төлөөлөгчдөд үйлчлэхэд хамтран ажиллах;</li> <li>4. Жуулчид, зочид төлөөлөгчдөд мэргэшсэн жолооч бүхий найдвартай, тав тухтай автомашины үйлчилгээг үзүүлэхэд хамтран ажиллах;</li> <li>5. Хамтын ажиллагааны ерөнхий чиглэл, цар хүрээ, дэвшилтэт санаа, үр дүнгийн талаар санал мэдээлэл солилцох, харилцан тохиролцох ажлуудыг тус тус хийж хэрэгжүүлэх юм.</li> </ol>	
5.1.4	БНСУ-ын Сэжун их сургуультай "Зочлох үйлчилгээний салбар"-ын хүний нөөцийг сургах, хөгжүүлэх ажилд хамтран ажиллах		Хамтын ажиллагааны талаар	Хүний нөөцийг бэлдэх чиглэлээр хамтын ажиллагааны санамж бичиг зурах	БНСУ-ын Сэжун их сургуулийн TIDAL захирал, АЖМХ-ны гүйцэтгэх захирал	<p>БНСУ-ын сэжун их сургуультай "зочлох үйлчилгээний салбар"-ын хүний нөөцийг сургах, хөгжүүлэх ажилд хамтран ажиллана</p> <p>Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо НЭЗХЭ-ийн Гүйцэтгэх захирал М.Нарангэрэл, Сэжун их сургуулийн Tourism Industry Data Analytics Lab (TIDAL) захирал Seul Ki Lee нар хамтран ажиллах САНАМЖ БИЧИГ-т гарын үсэг зурлаа.</p> <p>Хамтын ажиллагааны хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Монгол улсын аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарын хүний нөөцийг мэргэжлийн түвшинд хөгжүүлэх юм.</li> </ul> <p>Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо НЭЗХЭ, Сэжун их сургуулийн Tourism Industry Data Analytics Lab (TIDAL) хоёр байгууллага хоорондын харилцааг сайжруулах, ойрын жилүүдэд шинэ хамтын ажиллагаа хөгжүүлэх зорилгоор харилцан ашигтай харилцааг бий зорилготой.</p>	

5.1.5	БНСУ-ын Global Civic Sharing байгууллагатай хамтран ажиллах		Хамтын ажиллагааны талаар	Хүний нөөцийг бэлдэх чиглэлээр хамтын ажиллагааны санамж бичиг зураг	БНСУ-ын Global Civic Sharing байгууллагын захирал, АЖМХ-ны гүйцэтгэх захирал	<p>БНСУ-ын Global Civic Sharing байгууллагатай Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Монгол Улсад боловсрол, хөдөлмөр эрхлэлт, олон нийтийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр хамтран ажиллахаар САНАМЖ БИЧИГ зурлаа.</p> <p>Санамж бичгийг Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо НЭЗХЭ-ийн гүйцэтгэх захирал М. Нарангэрэлтэй Global Civic Sharing байгууллагын захирал Cho Hyunju, төслийн ахлах зохицуулагч Keehoon, Kim нартай зурав.</p> <p>Санамж бичгийн хүрээнд дараах хамтын ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Мэргэжлийн боловсролыг дэмжих сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад харилцан дэмжиж ажиллах</li> <li>2. МТО болон GCS нар сургалт, уулзалт зохион байгуулах, оролцох, харилцан мэдээлэл солилцох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, дадлагажуулах богино хугацааны сургалт зохион байгуулах, зөвлөн чиглүүлэх үйл ажиллагаанд хамтран ажиллахаар харилцан тохиролсон болно.</li> </ol> <p>Талуудын хамтарсан төсөл, хөтөлбөрийг энэхүү санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлэхээр боллоо.</p> <p>GCS байгууллага нь</p> <p>Бүгд Найрамдах Солонгос Улсын “Хөгжил дэх оролцооны төлөөх холбоо” “Жи си эс” /Global Civic Sharing/ Монгол Улсад 2002 оноос эхлэн хөдөө, орон нутагт нийгэм эдийн засгийн байдлыг сайжруулах, жижиг аж ахуйг хөгжүүлэх, орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх, зээл олгох, бусад сургалтад хамруулах, ижил төстэй байгууллагуудтай хамтрах ажилладаг.</p> <p>“Жи Си Эс” ТББ нь дэлхийн ядуурлыг бууруулах, байгалийн гамшиг болон дайны улмаас тайван бус байдал үүссэн улс орнуудад туслах, буурай хөгжилтэй орны иргэдийг чадваржуулах, хүйсийн тэгш байдлыг дэмжих, байгаль орчны тогтвортой байдлыг хамгаалах зорилготойгоор анх 1998 онд БНСУ-д байгуулагдсан олон улсын хөгжлийн байгууллага бөгөөд өнөөг хүртэл 8 оронд үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>GCSM (Global Civic Sharing Mongolia)</p> <p>1999-2001 оны их зудын үеэр амьдралын эх үүсвэр болох мал сүргээ алдсан малчин иргэдэд туслах, тэднийг малжуулж, өрхийн орлогыг нэмэгдүүлснээр орон нутгийн хөгжлийг дэмжих зорилготойгоор 2002 оноос Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш 16 жил болжээ энэ хугацаанд бидэнтэй хамт байсан</p>
5.1.6	МБШ төв Гандан тэгчэнлэн хийдтэй хамтран ажиллах	Оролцогчдын төлбөрөөс санхүүжүүлэв	Хамтын ажиллагааны талаар	Маркетинг сурталчилгаа, сургалт	МБШТ гандан тэгчэнлэн хийдийн гадаад харилцаа, сургалтын менежер, УЗ-ын гишүүд, Ажлын алба,	Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо болон Монголын Бурханы шашинтны Төв - Гандантэгчэнлин хийдийн төлөөлөгчидтэй уулзалт хийв. Аялал жуулчлалын чиглэлээр буддын шашны соёлыг жуулчдад таниулах тал дээр хамтран ажиллана.
5.1.7	COP-17 уулзалт		Хамтын ажиллагааны талаар	Зочдыг байрлуулах зочид буудал, жуулчны байзын хүрэлцээ	COP-17 ажлын хэсгийн дарга, зочид буудал хариуцсан менежер, Ажлын алба	Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, жуулчны бааз, байршуулах хэрэгсэлийн нөөц, даацын судалгааг гаргаж өгөх, стандарт хангалтын талаарх үзэл, шалгалт хийхээр хамтран ажиллана.
5.1.8	UNET consulting санхүүгийн зөвлөх үйлчилгээний байгууллага		Хамтран ажиллах	Судалгаа авах	UNET consulting санхүүгийн гүйцэтгэх захирал, АЖМХ-ны гүйцэтгэх захирал	Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчдэд бага хүүтэй, урт хугацааны зээл олгоход тавигдах шаардлагын талаар салбарынхнаас судалгаа авч, зээл олгоход хамтран ажиллана.
5.1.9	Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнтэй хамтран ажиллах		Хамтын ажиллагааны талаар	7 бүс дээр аялал жуулчлал хөгжүүлэх ажлууд дээр хамтран ажиллах	Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгийн захирал, менежер, АЖМХ-ны УЗ Ажлын алба	Аялал жуулчлалын салбарын уялдаа холбоог бүсчилсэн хөгжилтэй уялдуулах, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилготой. Аялал жуулчлал бол бүсүүдийн хөгжлийн тэргүүлэх чиглэл, гарцын нэг бөгөөд цаашдаа хил орчмын аялал жуулчлал, алтайн үзэсгэлэнт байгаль, нүүдэлчдийн өв соёл, олон ястны өвд тулгуурласан олон төрлийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, эргэлтэд оруулахдаа байгаль экологид халгүй байх зарчмыг баримтлах шаардлагатай. Бүсчилсэн хөгжил хөдөлгөөний хүрээнд Соёлын хосгүй үнэт өв, нүүдэлчин ахуй, байгалийн үзэсгэлэнт газар зэрэг газар зүйн байршлын давуу талд тулгуурласан аялал жуулчлалын тусгай бүсүүдийг байгуулах замаар орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжих зэрэг асуудлуудаар уулзалт хийсэн.

5.1.10	Жуулчны бааз байршуулах хэрэгсэлийн салбар холбоо		Хамтын ажиллагаа, туршлага солилцох	Гишүүддээ танилцах аялал хийж санал солилцох, зөвлөгөө өгөх	ЖББХСХ-ны гүйцэтгэх захирал, гишүүд	Овооны энгэр жуулчны баазын удирдлагууд Жуулчны бааз, байршуулах хэрэгсэлийн салбар холбооны гишүүдийг урьж ажлын туршлагаа солилцож, хамтран ажиллах уулзалт, өдөрлөг зохион байгуулагдсан. Тус уулзалтад ЖББХСХ -н гишүүдээс гадна Төв аймгийн аялал жуулчлалын салбар холбооны гишүүд хамтран зохион байгуулсан.
5.1.11	ССАЖЗЯ-ны Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар		Ажил танилцуулах	Гэрээний дагуух ажлын явцыг танилцуулах	ССАЖЗЯ-ны Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, мэргэжилтэнүүд, АЖМХ-ны Ажлын алба	Сургалт, судалгааны чиг үүрэгт харьяалагдах ажлуудын явцын талаар танилцуулсан. Үүнд: 2025 онд 4 төрлийн судалгаа, Эрдэм шинжилгээний хурал, Мэдлэгийн сан, Жуулчны хөтөч тайлбарлагчын үнэмлэх олгох шалгалтын ажилуудын талаарх ажлын явцыг танилцуулах уулзалт хийж санал солилцсон.
5.1.12	Гранд тур - 2025 Аялал жуулчлалын улсын олимпиад		Улсын олимпиадыг дэмжих ажиллах	Центавр тэмцээний даалгавар боловсруулах, шүүх		"ГРАНД ТУР-2025" аялал жуулчлалын Улсын XXIII олимпиадын #Хаврын тэмцээнүүд: Cecim Service бизнес загварчлалын цахим тэмцээн Центавр мэргэжлийн мэдлэг, ур чадварын тэмцээн Tourism Infographic content контент бүтээх тэмцээнүүд 2025 оны IY сарын 22-23-ны өдрүүдэд зохион байгуулагдсан ба Ц?нтавр тэмцээний даалгаваруудыг боловсруулж, шүүгчээр хамтран ажилласан байгаа. Уг тэмцээнд 17 их, дээд мэргэжлийн боловсролын сургуулийн 29 багийн 145 оюутан оролцож 3 үеийн турш мэдлэг, чадвараа сорин уралдаж шигшээ буюу 4-р үед 11 баг шалгарч өрсөлдсөн.
5.1.13	Жуулчин тээврийн салбар холбоо		Сургалт хийх	Постер хийж, хөтөлбөр боловсруулах	Жуулчин тээврийн салбар холбооны тэргүүн	Сургалтын хөтөлбөрийг 4 цагийн агуулгатай боловсруулсан. Постерыг хийж пэйж хуудас, сайт дээр тавьсан.
5.1.14	АТФ-2026 арга хэмжээ зохион байгуулах		Зохион байгуулах ажлын талаар	Зохион байгуулах үйл ажиллагааны чиг үүргийг тодорхойлсон	АЖМХ-ны УЗ, АЖБХН-н эрдмийн зөвлөл, ажлын алба	Азийн Аялал Жуулчлалын Форум (АТФ) нь 1993 онд Ази тивийн аялал жуулчлалын салбарт тулгарч буй хөгжлийн чиг хандлага, үйлчилгээний менежмент, маркетинг, тогтвортой байдлын асуудлуудыг хэлэлцэх зорилгоор байгуулагдсан. 15 дахь удаагийн "Азийн Аялал Жуулчлалын Форум 2026" нь "Зочлох Үйлчилгээ, Аялал Жуулчлалын Азийн Парадигм" сэдвийн хүрээнд 2026 оны 06-р сарын 11-13-ны өдрүүдэд Монгол улсын нийслэл Улаанбаатар хотноо зохион байгуулагдах гэж байна. Форумыг Хонгконгийн Политехникийн Их Сургуулийн Зочид Буудал, Аялал Жуулчлалын Менежментийн Сургууль болон Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо - НЭЗХЭ хамтран зохион байгуулах ажлын төлөвлөлт хийх уулзалтыг зохион байгуулсан.
5.1.15	НАЖГ-тай хийсэн уулзалт		Мэдээлэл солилцох	Стандарт үзлэг, шалгалтын тухай	НАЖГ-ын дарга, хэлтсийн дарга, АЖМХ-ны ажлын алба	Улаанбаатар хотын болон Улаанбаатар хот орчмын зочид буудал, жуулчны бааз, байршуулах хэрэгсэлийн стандартын үзлэг шалгалтын талаар уулзалт хийж, ажлын төлөвлөгөө, төсөв боловсруулсан.
5.1.16	АЖМХ-ны салбар холбоодын гүйцэтгэх удирдлагын уулзалт		Сургалт, мэдээлэл	Хууль, эрх зүйн, чиг үүргийн талаар	УЗ, Ажлын алба, Салбар холбоодын гүйцэтгэх удирдлага	WORKSHOP Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо болон Салбар холбоодын Гүйцэтгэх албаны нэгдсэн уулзалт, workshop болж байгаа ба өнөөдрийн уулзалтаар нэгдмэл нэг ойлголттой болох, хамтын ажиллагаагаа сайжруулах, гишүүдээ дэмжих агуулгын хүрээнд явагдсан.
5.1.17	СОР-17 уулзалт		Эрсдэлийн багийн уулзалт	Стандартын үзлэг шалгалтын талаар	СОР-17 ажлын алба, АЖМХ-ны УЗ, Ажлын алба	Цөлжилттэй тэмцэх Олон Улсын хуралд оролцох зочдын байрлах зочид буудал, жуулчны бааз, байршуулах хэрэгсэлийн үйл ажиллагаанд стандартын үзлэг шалгалт хийх уулзалтыг Онцгой байдлын ерөнхий газар дээр хийгдсэн. Ажлын хэсэг байгуулж хамтран ажиллах төлөвлөгөөг гаргаж үзлэг шалгалт хийгдэхээр төлөвлөж баталсан.
5.1.18	Авилгатай тэмцэх газрын сургалт		Сургалт	Авилгагчдын хор хөнөөл сэдвээр сургалт	АЖМХ-ны УЗ, Ажлын алба, тур оператор компаниуд	"Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо" нийтийн эрх зүйн хуулийн этгээд нь ССАЖЗ-ын Сайдтай байгуулсан "Төрийн зарим чиг үүргийг Засгийн Газрын бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай гэрээ"-ний дагуу үйл ажиллагаа явуулдаг юм. Иймд Авлигатай тэмцэх газарт, АЖМХ-ноос санал тавьж тус газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар С.Янжинлхам "АВЛИГАД ХЭРХЭН ӨРТӨХГҮЙ БАЙХ ВЭ" сэдвийн хүрээнд мэдээлэл өгч, сургалтыг зохион байгуулав. Хуралд АЖМХ-ны Удирдах зөвлөлийн гишүүд ажлын албаны албан хаагчид танхим болон онлайнгаар хамрагдлаа.

5.1.19	МОКТА солонгос зах зээлийн холбооны уулзалт		Уулзалт	Үйл жаиллагаа эрхлэх эрх зөрчигдөж байгаатай холбоотой уулзалт	Гадаадын иргэн харьяатын газрын дарга, мэргэжилтэн, АЖМХ-ны ажлын албаны гүйцэтгэх захирал, АЖМХ-ны МОКТА Солонгос зах зээлийн салбар холбооны тэргүүн, гишүүд	Монгол улсад гадаадын иргэн хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулж байгаатай холбоотой уулзалт хийгдсэн. Тус уулзалтаар салбарын хяналтын газартай хамтран хяналт шалгалт хийх талаар яригдсан. 48 цагийн бүртгэлтэй холбоотой гарын авлаг, танилцуулга, мэдээ мэдээллээр хангах ажлыг Гадаадын иргэн харьяатын газар эхлүүлэхээр болсон болно. Гадаадын иргэн харьяатын газар Аялал жуулчлалын тухай хуулиа мөрдөн ажиллахаар болов.		
5.1.20	Орхон аймагт хийсэн сургалт		Сургалт	Үйлчилгээний чанар, стандартын сургалт хийсэн	Зочлох үйлчилгээний бизнес эрхлэгч нарт	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам /ССАЖЗЯ/, Орхон аймгийн ЗДТГ, Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар СУАЖЗГ, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо /НЭЭХЭ/ хамтран Зочид буудлын үйлчилгээний стандартын онол, практик хосолсон 10 цагийн сургалтыг 2025 оны 07 сарын 01-ны өдөр Тэсоро зочид буулалд Орхон аймагт үйл ажиллагаа явуулж байгаа амралтын газар, зочид буудлын дарга, удирдлага менежер, үйлчилгээний албан хаагч 100 хүнийг хамруулсан	100%	
5.1.21	Жуулчны бааз, байршуулах хэрэгсэлийн стандартын хэлэлцүүлэг		Хэлэлцүүлэг	Байршуулах үйлчилгээний чанарын стандартад санал өгөх	Аялал жуулчлалын салбарт бизнес эрхлэх	Жуулчны бааз, Дэн буудлын стандартын хэлэлцүүлгийг 3 удаа зохион байгуулсан. Тус хэлэлцүүлгийг Жуулчны баазын холбоо болон Өргөө дэн буудал эрхлэгчдийн холбоотой хамтран уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулахдаа холбоодын хүрээнд 2 удаа, нийтийн хэлэлцүүлгийг үндэсний номын санд нэг удаа тус тус зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт ССАЖЗЯ-ын АЖБХЗГ-ын дарга В. Батчимэг, стандарт хариуцсан мэргэжилтэн М. Мөнхбилгүүн, Одбаяр нар, НАЖГ-ын Бодлогын хэлтсийн дарга С.Туул, АЖМХ-ны Гүйцэтгэх захирал М. Нарангэрэл, хуульч Р. Лхагвабаяр, ХЭЗСЧҮХ дарга Э.Тэнгисболд, ЖББХСХ-ны тэргүүн С. Алтантуяа гишүүдийн хамт тус тус бизнес эрхлэгчидтэй оролцож хэлэлцүүлгийг зохион байгуулсан.	100%	
Стратеги төлөвлөгөөний зорилго 6								
Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг бэлтгэх, мэргэжлийн удирдлагаар хангах, мэргэжлийн сургалтын чиглэлээр холбогдох иргэн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх								
6.1	Зорилт 1. Хамтарсан ажлын хэрэгжилт							
6.1.1	Жуулчин тээврийн жолооч нарт зориулсан нэгдсэн сан бүрдүүлэх, сургалтын сертификат олгох ажлыг зохион байгуулах		Тухайн ангиллаар жолооны эрхтэй болон мэргэшсэн жолооны үнэмлэхтэй байх, жуулчин тээврийн мэргэшүүл эрхтэй байх		Журмын хэрэгжилтийг мөрдсөн, жуулчин тээврийн аюулгүй байдлыг бүрэн хангасан байх	Жуулчин тээврийн үйлчилгээ үзүүлэгч жолооч нарт сертификат олгох сургалтыг зохион байгуулсан. Энэхүү сургалтаар жуулчин тээврийн жолооч нарт Хууль эрх зүй, Техникийн бүрэн бүтэн байдал, Жолоочийн ёс зүй, Авто аяллын онцлог, хөгжил зэрэг агуулгуудыг багтаасан цогц сургалт болж чадсан. Эхний сургалт 2025 оны 05 сарын 05-ны өдөр Зам Тээврийн яамны харьяа "Их нүүдэл" хурлын зааланд болсон бөгөөд нийт 217 жолооч хамрагдсан. 2 дахь сургалт 2025 оны 05 сарын 12-ны өдөр Зам Тээврийн яамны харьяа "Их нүүдэл" хурлын зааланд мөн адил болсон ба нийт 211 жолооч хамрагдсан. 3 дахь сургалт 2025 оны 05 сарын 13-ны өдөр Өмнөговь аймгийн Даланзадгад хотын 5-р багийн хурлын зааланд болсон ба нийт 82 жолооч хамрагдсан. 4 дэх сургалт 2025 оны 05 сарын 29-ны өдөр Аялал жуулчлалын сургалтын төвийн байранд болсон ба нийт 124 жолооч тус тус хамрагдсан. Нийт 634 жолооч нарт сургалт орсон бөгөөд үүнээс 608 сертификатыг жолоочдод олгоод байна.	100%	

6.1.2	Жуулчин тээврийн салбарт тулгамдаж буй асуудлыг тодорхойлох		Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, НЭЗЭХ, Жуулчин тээврийн салбар холбооны гишүүнчлэлтэй тур оператор компаний тодорхойлолттой жолооч байх, Тухайн ангиллаар жолооны эрхтэй болон мэргэшсэн жолооны үнэмлэхтэй байх, жуулчин тээврийн мэргэшүүлэхтэй байх	Салбарын тулгамдаж буй асуудлаар	Монгол улсад ирж байгаа жуулчдын эрэлттэй уялдуулан жуулчин тээврийн үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэх	2025-2028 оныг Монгол Улсын Засгийн газраас аялал жуулчлалыг дэмжих жил болгосонтой холбогдуулан, нэг сая жуулчин авах зорилтод хүрэх, аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлэх хүрээнд авто тээврийн хэрэгслийн эрэлтийг тасралтгүй хангах, нөгөөтэйгүүр энэ салбарт ажилладаг туршлагатай жолооч нарыг дэмжих зорилгоор жуулчин тээвэрт түгээмэл ашигладаг тээврийн хэрэгслүүдэд "Жуулчин" таних тэмдгийг Зам тээврийн яам болон Авто тээврийн үндэсний төвтэй хамтран 268 тээврийн хэрэгсэлд (Альфард, Делика, Тоёота Хайс, Фургон, Старекс) олгоод байна.	89.33%
Стратеги төлөвлөгөөний зорилго 7 Аялал жуулчлалын салбарыг идэвхжүүлэх, гишүүнчлэлийг нэмэгдүүлэх							
7.1	Зорилт 1. Ажлын хэрэгжилт						
7.1.1	2023 оны 05 сарын 04-ны өдрийн Аялал жуулчлалын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 26-р зүйлд заасны дагуу, ССАЖЗЯ болон АЖМХ хоорондын Төрийн зарим чиг үүргийг засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай гэрээний 4.12-т заасны дагуу		Хуулийн хүрээнд байгуулагдсан, АЖМХ-ы Удирдах зөвлөлийн баталсан журмын дагуу бичиг баримтыг бүрдүүлсэн байгууллага байх	2024 оны эцэст нийт гишүүдийн тоо: 400 гаруй	2025 оны гишүүнчлэлийн өсөлт 10 хувиас доошгүй байх	2025 оны байдлаар холбооны бүртгэлтэй гишүүдийн нийт тоо 561. Энэ нь 2024 оны эцэст бүртгэгдсэн 400 гишүүнтэй харьцуулахад 40.25хувийн өсөлттэй байна.	100%
2. Салбар холбоодын үйл ажиллагааг дэмжин ажиллах							
7.2	А. Бүрэн эрхт салбар холбоод						

7.2.1	Хятад зах зээлийн салбар холбоо				<p>1. Хятадын Соёлын төв болон БНХАУ-ын Элчин сайдын яамтай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, Монгол-Хятадын аялал жуулчлал, соёлын чиглэлээр хамтын ажиллагааг эхлүүлэв.</p> <p>2. Агаарын тээвэр, аялал жуулчлалын чиглэлээр хамтын ажиллагааны ажлуудыг эхлүүлэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>o Spring Airlines компанитай хамтын ажиллагаа эхлүүлсэн (түр зогссон);</li> <li>o China United Airlines компанитай хамтран Улаанбаатар–Ордос чиглэлийн нислэгийг эхлүүлэх ажлыг зохион байгуулж, 2025 оны 7 дугаар сараас нислэг үйлдэж эхлэв;</li> <li>o Нислэгийг идэвхжүүлэх, тийзийн мэдээллийг TO компаниудад түгээх чиглэлээр уулзалтууд зохион байгуулав.</li> </ul> <p>3. Олон улсын аялал жуулчлалын компаниудтай хамтын ажиллагааг өргөжүүлэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>o Өвөр-Монголын CITS болон CYTS компаниудтай хамтын ажиллагаа эхлүүлж, мэдээлэл солилцох WeChat групп үүсгэв;</li> <li>o Хайнан мужийн аялал жуулчлалын компаниудтай хамтын ажиллагаа тогтоож, олон улсын үзэсгэлэнд оролцох дэмжлэг авч ажиллав;</li> <li>o Эрээн хотын Соёл, аялал жуулчлалын корпорацийтай хамтран экспо болон эвент зохион байгуулав.</li> </ul> <p>4. Олон улсын аялал жуулчлалын арга хэмжээ, чуулгануудад идэвхтэй оролцов. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>o Хубэй мужийн олон улсын аялал жуулчлалын чуулганд оролцож, харилцаа холбоо тогтоов;</li> <li>o Хубэй мужид зохион байгуулагдсан фам тур болон туршлага судлах айлчлалд оролцов;</li> <li>o Ханжоу хотод болсон олон улсын уулзалтад оролцож, хөрөнгө оруулалт болон хамтын ажиллагааны боломжуудыг судлав;</li> <li>o Шинжааны олон улсын өвлийн аялал жуулчлалын хуралд оролцож, бүс нутгийн туршлага судлав.</li> </ul> <p>5. Монголын аялал жуулчлалыг гадаад зах зээлд сурталчлах ажлыг хэрэгжүүлэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>o "GoMongolia" авто аяллын сурталчилгааг БНХАУ-ын 10 хотод зохион байгуулав;</li> <li>o Монгол Улсын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, чиглэлийг гадаад зах зээлд танилцуулах ажлуудыг хэрэгжүүлэв.</li> </ul> <p>6. Бүс нутгийн аялал жуулчлалын хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр дараах ажлуудыг хэрэгжүүлэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>o Хубэй муж болон БНХАУ-ын аялал жуулчлалын байгууллагуудтай тогтмол харилцаа тогтоов;</li> <li>o Шинжаан, Өвөр-Монгол зэрэг бүс нутгуудтай хамтын ажиллагааны суурийг тавив;</li> <li>o Монголын баруун бүсийн аймгуудыг (Баян-Өлгий, Увс, Ховд) БНХАУ-ын аялал жуулчлалын байгууллагуудтай холбох ажлыг эхлүүлэв.</li> </ul>
7.2.2	Жуулчны бааз, Байршуулах хэрэгслийн салбар холбоо;				<p>1. Жуулчны бааз, байршуулах хэрэгслийн салбар холбооны удирдлагын болон зохион байгуулалтын үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>o Удирдах зөвлөлийн хурлуудыг тухай бүр зохион байгуулсан;</li> <li>o Гүйцэтгэх захирлыг томилж, үйл ажиллагааг тогтворжуулсан;</li> <li>o Гишүүдийн татварын үлдэгдлийг төвлөрүүлж, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулсан.</li> </ul> <p>2. Салбарын судалгаа, бодлогын ажлуудыг хэрэгжүүлэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>o "Жуулчны бааз, байршуулах үйлчилгээний нөхцөл байдлын суурь судалгаа"-г эхлүүлж, 80 гаруй байгууллагыг хамруулсан;</li> <li>o Жуулчны баазын зэрэглэл, стандартын хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан;</li> <li>o Байгаль орчин, тусгай хамгаалалттай газар нутгийн хуулийн шинэчилсэн найруулгын хэлэлцүүлэгт оролцож, санал хүргүүлсэн.</li> </ul> <p>3. Салбарын сургалт, хүний нөөцийн чадавхжуулалтын ажлуудыг зохион байгуулав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>o Жуулчны баазын менежерүүдэд зориулсан сургалт, туршлага солилцох өдөрлөгүүдийг зохион байгуулсан;</li> <li>o Хүний нөөцийн бодлогын чиглэлээр чөлөөт уулзалтууд хийсэн;</li> <li>o ШУТИС болон бусад боловсролын байгууллагуудтай хамтран сургалт, дадлагын боломжийг судалсан.</li> </ul> <p>4. Салбарын хамтын ажиллагаа, уялдаа холбоог бэхжүүлэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>o Дотоодын болон олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан;</li> <li>o Тур операторуудтай хамтарсан уулзалт зохион байгуулж, хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр ажилласан;</li> <li>o Аялал жуулчлалын салбарын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлсэн.</li> </ul> <p>5. Аялал жуулчлалын томоохон арга хэмжээнүүдэд идэвхтэй оролцов. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>o Tourism Week арга хэмжээнд оролцож, В2В уулзалтад 100 гаруй байгууллагыг хамруулсан;</li> <li>o Салбарын судалгааны үр дүнг танилцуулж, илтгэл тавьсан;</li> <li>o Аялал жуулчлалын сургалтын төв, үзэсгэлэн, өдөрлөгүүдэд оролцсон.</li> </ul> <p>6. Салбарын гишүүдэд чиглэсэн мэдээлэл, дэмжлэгийн үйл ажиллагааг хэрэгжүүлэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>o Гадаадын иргэнийг бүртгэх журам, зээлийн боломж зэрэг мэдээллийг түгээсэн;</li> <li>o Эрчим хүчний хөнгөлөлтийн буцаан олголтыг 100 гаруй сая төгрөгөөр гишүүдэд олгуулсан;</li> <li>o Сэргээгдэх эрчим хүч болон тогтвортой хөгжлийн чиглэлээр судалгаа, оролцоог нэмэгдүүлсэн.</li> </ul>

7.2.3	"Америк Монголын Аялал Жуулчлалын Хөгжлийн Тэгш Нийгэмлэг" ТББ				<p>1. Дижитал платформ хөгжүүлэв. AMTourism.org вебсайтыг хөгжүүлж, гишүүдийн мэдээллийг нэгтгэсэн, АНУ-ын зах зээлд чиглэсэн нэгдсэн платформыг ажиллуулсан.</p> <p>2. Сургалт, чадавхжуулалтын үйл ажиллагаа хэрэгжүүлэв. WIX вебсайт хөгжүүлэлт, Task management, KPI тооцоолол, SEO чиглэлээр гишүүдэд сургалт зохион байгуулсан.</p> <p>3. Олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэв. USTOA-д гишүүнээр элсэж, олон улсын зах зээлд нэвтрэх суурийг бүрдүүлж, 2025 оны арга хэмжээнд оролцох бэлтгэлийг хангасан.</p> <p>4. Удирдлага, зохион байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэв. Удирдах зөвлөл болон гишүүдийн хурлуудыг зохион байгуулж, гүйцэтгэх захирлыг томилсон.</p> <p>5. Санхүүгийн үйл ажиллагааг хэрэгжүүлэв. Холбооны банкны дансыг нээж, 11 сая төгрөгийн санхүүжилтээр үйл ажиллагааг ханган ажилласан.</p>
7.2.4	Эртний нүүдэлчдийн өлгий Архангай аймгийн аялал жуулчлалын холбоо ГҮТББ				<p>1. Сурталчилгаа, контент хөгжүүлэлтийн ажлыг хэрэгжүүлэв. Малчин кемп айлуудын газрын зургийг боловсруулж хэвлүүлэн олон нийтэд түгээсэн.</p> <p>2. Салбарын бүтээгдэхүүн сурталчлах ажлыг хэрэгжүүлэв. Tourism Week болон бүсийн чуулганы хүрээнд малчин кемп болон холбооны үйл ажиллагааг сурталчилсан.</p> <p>3. Орон нутгийн аялал жуулчлалын идэвхжүүлэлтийг дэмжив.</p>
7.2.5	Европ зах зээлийн салбар холбоо				<p>1. Олон улсын үзэсгэлэн, арга хэмжээнд оролцох ажлыг зохион байгуулсан. ITB Berlin, IFM Top Resa зэрэг үзэсгэлэнд гишүүн байгууллагуудыг амжилттай оролцуулсан.</p> <p>2. Олон улсын зах зээлд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Budapest Road Show болон Poland Fam tour арга хэмжээнд гишүүдийн оролцоог хангаж, Монголыг сурталчилсан.</p> <p>3. Салбарын гишүүнчлэл, зохион байгуулалтыг бэхжүүлсэн. Гишүүдийн тоог нэмэгдүүлж, удирдах зөвлөлийн хурлуудыг зохион байгуулсан.</p> <p>4. Нийгмийн хариуцлагын үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. "Тэрбум мод" аяны хүрээнд мод тарих ажилд оролцсон.</p>
7.2.6	Монгол Солонгосын Зах Зээлийн Аялал Жуулчлалын Холбоо				<p>1. Сургалт, чадавхжуулалтын үйл ажиллагаа хэрэгжүүлэв. ХАБЭА, эрсдэлийн удирдлага болон инбаунд стандартын сургалтуудыг зохион байгуулсан.</p> <p>2. Сурталчилгаа, олон улсын арга хэмжээнд оролцов. KOTFA болон Travel Show олон улсын үзэсгэлэнд оролцож, зах зээлд сурталчилгаа хийсэн.</p> <p>3. Хамтын ажиллагаа, салбарын уялдаа холбоог бэхжүүлэв. NUBIA, МОКТА болон агаарын тээврийн байгууллагуудтай хамтарсан уулзалтыг зохион байгуулсан.</p> <p>4. Нийгмийн болон сайн дурын үйл ажиллагааг хэрэгжүүлэв. "Хоггүй Тэрэлж" аян болон "Жуулчин төгөл" арга хэмжээнд оролцож, хандив, дэмжлэг үзүүлсэн.</p>
7.2.7	"Төв Аймгийн Аялал Жуулчлалын Холбоо" ТББ				<p>1. Гишүүдийн хурал, мэдээлэл солилцооны үйл ажиллагааг зохион байгуулсан. Бүх гишүүдийн хурлыг зохион байгуулж, салбарын бодлого, хамтын ажиллагаа, АЖМХ-ны үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэсэн.</p> <p>2. Салбарын арга хэмжээ, шагнал урамшууллыг хэрэгжүүлсэн. Шинэ жилийн арга хэмжээ зохион байгуулж, гишүүдийг шагнаж урамшуулсан бөгөөд Tourism Awards-д гишүүдийг нэр дэвшүүлж амжилттай оролцуулсан.</p> <p>3. Салбарын уулзалт, сургалт, арга хэмжээнд идэвхтэй оролцсон. АЖМХ-ны уулзалт, Tourism Week зэрэг арга хэмжээнд тогтмол оролцож, гишүүдийн оролцоог ханган ажилласан.</p> <p>4. Туршлага солилцох, хүний нөөцийн хамтын ажиллагааг хөгжүүлсэн. Салбар дундын туршлага солилцох аялал зохион байгуулж, МСҮТ-тэй хамтран оюутнуудыг дадлагажуулах, ажиллуулах нөхцөлийг бүрдүүлсэн.</p> <p>5. Олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлсэн. ӨМӨЗО-ны байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, олон улсын арга хэмжээнд хамтран оролцсон.</p> <p>6. Салбарын арга хэмжээ, төлөвлөлт, зохион байгуулалтыг хэрэгжүүлсэн. "Баргажин-2025" наадамд оролцож, ITM 2025 үзэсгэлэнд оролцох бэлтгэлийг ханган, Удирдах зөвлөлийн хурлуудаар үйл ажиллагааг тогтмол хэлэлцэн шийдвэрлэсэн.</p>

7.2.8	"Монголын Мэргэжлийн Хөтөч Тайлбарлагчийн Холбоо"ТББ				<p>1. Хөтөч тайлбарлагчийн мэргэжлийн сургалтуудыг зохион байгуулсан. 2025 оны 1–5 дугаар саруудад шат дараатай сургалтуудыг зохион байгуулж, гишүүдийн оролцоог ханган ажилласан.</p> <p>2. Мэргэжлийн арга хэмжээ, өдөрлөгийг хэрэгжүүлсэн. Дэлхийн хөтөч тайлбарлагчдын өдөрт зориулсан өдөрлөгийг зохион байгуулсан.</p> <p>3. Мэргэжлийн үнэлгээ, шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Жуулчны хөтөч тайлбарлагчийн үнэмлэх олгох шалгалтыг зохион байгуулсан.</p> <p>4. Музейн тайлбарлах үр чадварын чиглэлээр сургалт зохион байгуулсан. Монголын Үндэсний музей, Чингис Хаан Үндэсний музейд англи, солонгос хэл дээр тайлбарлах сургалтуудыг зохион байгуулсан.</p> <p>5. Салбарын онцлог сургалтуудыг хэрэгжүүлсэн. Буддын шашны суурь ойлголт, шүтээн урлал, Гандантэгчэнлин хийдийн талаар мэргэжлийн сургалт зохион байгуулсан.</p> <p>6. Сургалтын үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлсэн. Бүх сургалтуудыг төлөвлөсөн хугацаанд амжилттай зохион байгуулж, салбарын хүний нөөцийн чадавхыг дээшлүүлсэн.</p>
7.2.9	Аялал жуулчлалын боловсрол хөгжлийн нийгэмлэг				Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг дэмжих зорилгоор 1 тэрбум тэтгэлэгт дадлагад амжилттай хамрагдсан 20 оюутанд тэтгэлэг олгох асуудлыг АМЖХ-ны УЗ-ын шийдвэрээр олгохоор болсон байна. Тус шийдвэрээр 30 оюутнуудыг тус бүр 1,5 сая төгрөг, нийт 30 сая төгрөг олгохоор шийдвэрлэв.
7.2.10	Дорноговь Аймгийн Аялал Жуулчлалын Холбоо				Дорноговь аймгийн Аялал жуулчлалын холбоо 2025 онд шинээр байгуулагдан үйл ажиллагаагаа эхлүүлсэн. 2025 оны хугацаанд орон нутгийн тур оператор байгууллагуудыг мэргэжлийн холбоонд элсүүлж, 02 дугаар сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрээр 05 дугаар сараас бүрэн эрхт салбар холбоо болон үйл ажиллагаа явуулж байна.
7.2.11	Монголын жуулчин тээврийн холбоо				<p>1. Жуулчин тээврийн жолооч нарын судалгааг зохион байгуулсан. 957 жолоочийг хамруулсан судалгааг хэрэгжүүлсэн.</p> <p>2. Жуулчин тээврийн жолооч нарын сургалтыг зохион байгуулсан. Улаанбаатар болон орон нутгагт нийт 644 жолоочийг хамруулсан сургалтыг зохион байгуулсан.</p> <p>3. Жуулчин тээврийн зөвшөөрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. 277 жолоочид зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулсан.</p> <p>4. Нийгмийн хариуцлагын үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. "Тэрбум мод", "Жуулчин төгөл" ажлын хүрээнд мод тарих үйл ажиллагаанд мод тарих болон тээврийн хэрэгслээр ханган оролцсон.</p>
7.2.12	Гадаад аяллын салбар холбоо				Гадаад аяллын салбар холбоо 2025 оны 07 дугаар сарын 31-ний өдөр шинээр байгуулагдан бүрэн эрхээ авсан. Одоогоор 35 гишүүн байгууллагатайгаар үйл ажиллагаа явуулж эхэлсэн.
Б. Хязгаарлагдмал эрхт салбар холбоод					
7.2.13	Монгол Японы Аялал Жуулчлалын салбар холбоо НҮТББ/рд: 8149666				<p>1. Олон улсын үзэсгэлэнд оролцох ажлыг зохион байгуулсан. Tourism Expo Japan 2025 үзэсгэлэнд Монгол Улсаас оролцох байгууллагуудыг сонгон бүртгэх ажлыг Аялал жуулчлалын мэргэжлийн холбоотой хамтран зохион байгуулсан.</p> <p>2. Олон улсын болон дотоодын уулзалтуудыг зохион байгуулсан. Япон улсын аялал жуулчлалын байгууллагууд, агаарын тээврийн компаниуд болон холбогдох талуудтай уулзалтуудыг зохион байгуулж, хамтын ажиллагааг өргөжүүлсэн.</p> <p>3. Бүх гишүүдийн хурлыг зохион байгуулсан. Холбооны бүх гишүүдийн хурлыг зохион байгуулж, цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөө, хамтын ажиллагаа, бодлогын асуудлуудыг хэлэлцсэн.</p>
7.2.14	Булган аймгийн аялал жуулчлалын холбоо НҮТББ/рд: 8149666				<p>"Монгол Улсын үзэл баримтлал батлах тухай" тогтоолын хүрээнд хийгдэж буй "Хойд бүс"-ийн нээлтийн арга хэмжээ 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Булган аймагт болсон.</p> <p>Хойд бүсийн зөвлөл анхдугаар хуралдаан 2025 оны 04 сарын 28-ны өдөр Хойд бүсэд хамраах Булган, Орхон, Хөвсгөл аймгуудыг хамарсан хуралдаан Булган аймгийн Спортын төвд өглөө 09:00 цагт нэгдсэн хуралдаанаар эхэлсэн. Хурлын дараа панелист хэлэлцүүлэг эхэлсэн.</p>

7.2.15	Сэлэнгэ аймаг дахь Аялал жуулчлалын "ТАВАН ХАН" ТББ салбар холбоо				<p>"СЭЛЭНГЭЭР АЯЛАХУЙ" аялал жуулчлалын салбар зөвлөгөөн Сэлэнгэ аймагт 10 дугаар сарын 3,4-ний өдрүүдэд болсон бөгөөд тухайн хурал дээр санамж бичиг зурагдсан. Хугацаа: 2025.10.03–04   Байршил: Сэлэнгэ аймаг</p> <p>Зорилго: Аялал жуулчлалын салбарын хөгжлийн чиглэл, хамтын ажиллагааг тодорхойлох, төр-хувийн хэвшил-орон нутгийн уялдааг сайжруулах.</p> <p>Оролцогчид: ССАЖЗЯ, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, Сэлэнгэ аймгийн ЗДТГ, салбарын эрдэмтэн, судлаачид, бизнес эрхлэгчид, зочид буудал, жуулчны бааз, ресторан, тээвэр, гар урлал, хөтөч зэрэг байгууллагууд</p> <p>Гол агуулга: Сэлэнгэ аймгийн аялал жуулчлалын боломж (агро, эко, хил орчмын, түүх соёлын аялал)-ыг тодорхойлж, тулгамдсан асуудал, шийдлийг хэлэлцэн, олон улсын туршлага солилцлоо</p> <p>Салбар хуралдаан: Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ   Зочид буудал   Амралтын газар, жуулчны бааз</p> <p>Стандарт: MNS 4588:2008, MNS 5927:2008, MNS 6043:2023</p> <p>Сэлэнгэ аймагт: Жуулчны бааз 42, Зочид буудал 25, 4 улирлын амралтын газар 9   Жилд: Дотоодын ~401,000, Гадаад ~211,000 жуулчин</p> <p>Сэлэнгэ аймгийн ЗДТГ-тай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж, бүсчилсэн хөгжлийг дэмжих, жуулчны тоог нэмэгдүүлэх, орон нутгийн оролцоог идэвхжүүлэх чиглэлд хамтран ажиллахаар болов. Тус зөвлөгөөн нь орон нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого, хамтын ажиллагааг нэгтгэсэн чухал арга хэмжээ болсон.</p>
7.2.16	НИТАЖ эрхлэгчдийн салбар холбоо				<p>Салбар холбооны гишүүнчлэлийг нэмэгдүүлэх, НИТАЖ эрхлэгчдийг чадавхжуулах, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр 2025 онд дараах ажлуудыг зохион байгуулсан.</p> <p>2025 оны 5 дугаар сарын 20-ны өдөр Хөвсгөл аймагт салбар холбоонд гишүүн элсүүлэх зорилготой уулзалт зохион байгуулж, НИТАЖ эрхлэгчдэд зориулсан мэдээллийг сум, орон нутгийн удирдлагуудтай хамтран хүргэж, сургалтууд зохион байгуулсан.</p> <p>Үүний зэрэгцээ Хөвсгөл аймгийн 23 сум, 1 тосгоны НИТАЖ эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийн группийг тогтмол ажиллуулж, зөвлөгөө мэдээлэл хүргэн, сум бүрт малчин айлуудыг жуулчин хүлээн авах түвшинд дадлагажуулан чадавхжуулах ажлыг хэрэгжүүлсэн.</p> <p>Мөн Орхон, Булган, Дорноговь, Ховд аймгийн НИТАЖ эрхлэгчид болон малчин айлуудын хоршоодтой хамтын ажиллагааны уулзалт, хурлуудыг зохион байгуулж, харилцан туршлага солилцох, хамтын ажиллагааг өргөжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.</p> <p>2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр спорт өдөрлөг зохион байгуулж, гишүүдийн уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах арга хэмжээ хэрэгжүүлсэн.</p> <p>2025 оны 12 дугаар сарын 25-ны өдөр шинэ жилийн арга хэмжээ зохион байгуулж, гишүүдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг дэмжих ажлыг зохион байгуулсан.</p>